⁴ Ихэвчлэн 0.05 хувь.

⁵ Зөвшөөрөх хоцролтын хугацааг орлуулж бичнэ.

харгалзах зорилгоор төлбөрийн хуваарьт зааснаас өмнөтөлөгдөх дүнд сарын ТШӨХ-д заасан хувь⁶-тай тэнцэхүү тооцож тендерийн үнэ дээр нэмнэ.

34.5. Хэрэв тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэх ажил нь ТООЗ-ын 1.3-ийн дагуу хоёр буюу түүнээс дээш багцад хуваасан бол захиалагч үнэлгээг дараах байдлаар хийнэ. Үүнд:

- (а) багц тус бүрт ТООЗ-ны 34.1-34.3-т заасны дагуу тендерийн үнэлгээг хийж, харьцуулах хамгийн бага үнэтэй тендерийг тодорхойлох;
- (б) хоёр буюу түүнээс дээш багцад гэрээ байгуулах эрх авсан тохиолдолд нөхцөлт үнийн хөнгөлөлт үзүүлэхээр санал болгосон тендерт уг нөхцөлт үнийн хөнгөлөлтийг тооцох;
- (в) дээрх үнэлгээг хийсний дараа захиалагч гэрээ байгуулах эрхийг нэг багцад, хэд хэдэн багцад, эсвэл бүх багцад олгох хувилбаруудыг тооцож, тэдгээрээс хамгийн үр ашигтай хувилбарыг сонгох;
- (г) нэг тендерт оролцогчид хоёр буюу түүнээс дээш багцад гэрээ байгуулах эрх олгох тохиолдолд тухайн этгээд гэрээг хэрэгжүүлэх чадварын шаардлагыг хангаж буй эсэхийг дахин магадлах. Хэрэв чадварын шаардлага хангахгүй бол тухайн этгээдэд гэрээ хэрэгжүүлэх чадварт нь тохирох багцад гэрээ байгуулах эрх олгож болно.

34.6. Шаардлагад нийцсэн тендерүүдийг ТООЗ-ны 34.2, 34.3 болон 34.5-д заасны дагуу үнэлж, харьцуулах үнийг тогтоосний үндсэн дээр хамгийн бага харьцуулах үнэтэй тендерийг хамгийн сайн үнэлэгдсэн тендер гэж шалгаруулна. Хамгийн сайн үнэлэгдсэн үндсэн тендерийн хувилбарт тендер үндсэн тендерээс илүү нөхцөл хангасан бол хувилбарт тендерийг шалгаруулна.

35. Тендерт оролцогчийн чадварыг дахин магадлах

- 35.1. Захиалагч шаардлагад нийцсэн, хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогч гэрээг хэрэгжүүлэх чадвартай эсэхийг дахин магадлаж болно.
- 35.2. Тендерт оролцогчийн чадварыг тодорхойлохдоо ТООЗ-ны 5.1-д заасны дагуу тендерт оролцогчийн ирүүлсэн чадварыг нотлох баримт болон ТООЗ-ны 29 дүгээр зүйлийн дагуу хийсэн шаардлагатай нэмэлт тодруулгад үндэслэн ТООЗ-ны 5.3-т заасан чадварын шаардлагыг хангасан эсэхийг тодорхойлно. Захиалагч ТООЗ-ны 18.2 болон тендерийн үнэлгээнд харгалзах чадварын шалгуур үзүүлэлтэд заагаагүй бусад шалгуур үзүүлэлтийг тендерийг хянан үзэх, тендерт оролцогчийн чадварыг тогтооход ашиглахгүй.
- 35.3. “Хамгийн сайн” үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчийн гэрээ хэрэгжүүлэх чадварыг дахин магадлаад шаардлага хангасан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгоно. Хэрэв шаардлага хангахгүй бол уг тендерээс татгалзан сайн гэж үнэлэгдсэн дараагийн тендерт оролцогчийн чадварыг мөн адил зарчмаар магадлана.

36. Аливаа тендерийг сонгох, эсхүл тендерүүдээс татгалзах

- 36.1. Захиалагч тендер шалгаруулалтыг үндэслэлгүйгээр хүчингүй болгохыг хориглоно.

⁶ Энэ хүү нь тендер зарлах үеийн тендерийн валютын арилжааны зээлийн зонхилох хүү байна.

Е. ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ЭРХ ОЛГОХ

- 37. Гэрээ байгуулах эрх олгох шалгуур**
- 37.1. Захиалагч шаардлагад нийцсэн бөгөөд 34.6-д заасны дагуу хамгийн сайн гэж үнэлэгдсэн тендер ирүүлсэн тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгоно.
- 37.2. Хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогч ТООЗ-ны 31 дугаар зүйлийн дагуу захиалагчийн залруулсан арифметик алдааг хүлээн зөвшөөрөөгүй эсвэл бичгээр хариу ирүүлээгүй бол захиалагч түүний тендерээс татгалзах бөгөөд 21.8.(б)-д заасны дагуу тендерийн баталгааг улсын орлого болгож, хуулийн 29.3 дахь хэсэгт заасныг үндэслэн удаахь хамгийн сайн үнэлэгдсэн тендер шрүүлсэн оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 38. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 38.1. Захиалагч нь гэрээ байгуулах эрх олгосон тухай мэдэгдлийг тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө шалгарсан тендерт оролцогч болон бусад тендерт оролцогчид нэгэн зэрэг бичгээр хүргүүлнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу нийлүүлэгдэх бараанд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.
- 38.2. Гэрээ байгуулах эрх олгох мэдэгдлийг бүх тендерт оролцогчдод нэгэн зэрэг мэдэгдсэнээс хойш ажлын 6 хоногийн дотор гэрээг баталгаажуулж гарын үсэг зурахыг хориглоно. Энэ заалтыг зөрчиж байгуулсан гэрээ нь хуулийн 42.1.2-т зааснаар хүчин төгөлдөр бус гэрээ гэж тооцох үндэслэл болно.
- 38.3. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл нь гэрээ байгуулах үндэслэл болно. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл гаргаснаар тендерт оролцогч 40 дүгээр зүйлийн дагуу гүйцэтгэлийн баталгаа ирүүлж, 39 дугаар зүйлийн дагуу гэрээнд гарын үсэг зурах хүртэл захиалагч гэрээ байгуулах эрх авсан тендерт оролцогч нарын хооронд хэлцэл хийгдсэн гэж үзнэ.
- 38.4. Захиалагч нь Засгийн газрын худалдан авах ажиллагааны цахим хуудас www.e-procurement.mn вэб сайтад тендерийн нэр болон багцийн дугаарыг дараах мэдээллийн хамтаар нийтэлнэ:
- 1) Тендер ирүүлсэн оролцогч бүрийн нэр;
 - 2) Тендерийн нээлтэнд зарлагдсан үнийн саналууд;
 - 3) Нарийвчлан үнэлэгдсэн тендерийн нэр, үнийн санал;
 - 4) Тендерээс нь татгалзсан оролцогчийн нэр, татгалзсан шалтгаан;
 - 5) Тендерт шалгарсан оролцогчийн нэр, түүний санал болгосон үнэ, түүнчлэн батлагдсан гэрээний дүн.
- 38.5. Гэрээ байгуулсан тухай мэдээлсний дараагаар, шалгараагүй тендерт оролцогч тендерийг нь татгалзсан үндэслэл, шалтгааны талаар тайлбар ирүүлэх хүсэлтийг бичгээр гаргаж болно. Ийм хүсэлт гаргасан тохиолдолд захиалагч бичгээр хариу өгнө.
- 38.6. Шалгарсан тендерт оролцогч ТООЗ-ын 40 дүгээр зүйлийн дагуу гүйцэтгэлийн баталгаа ирүүлж, гэрээнд гарын үсэг зурсны дараагаар захиалагч ТООЗ-ын 21.8-д заасан хугацаанд тендерийн баталгааг цуцлах талаар бусад тендерт оролцогч нарт мэдэгдэнэ.

- 39. Гэрээнд гарын үсэг зурах**
- 39.1. Захиалагч нь гэрээний маягт болон талуудын хооронд тохирсон бүх нөхцөлүүдийг тусгасан тохиролцоог гэрээ байгуулах эрх олгох мэдэгдлийн хамт шалгарсан тендерт оролцогчид илгээнэ.
- 39.2. Шалгарсан тендерт оролцогч нь гэрээний маягтыг хүлээн авснаас хойш ажлын 6-аас дээш хоногийн дараа ТШӨХ-д тусгайлан заасан хоногийн дотор түүнд гарын үсэг зурж захиалагчид хүргүүлнэ.
- 39.3. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчийг гүйцэтгэлийн баталгаа ирүүлсэн даруй гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулна.
- 40. Гүйцэтгэлийн баталгаа**
- 40.1. Шалгарсан тендерт оролцогч ТШӨХ-д тусгайлан заагаагүй тохиолдолд гүйцэтгэлийн баталгаа ирүүлэхгүй байж болно. Гүйцэтгэлийн баталгааг гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл хүлээн авснаас гэрээний тусгай нөхцөлд заасан дүнгээр, ТШӨХ-д заасан маягтаар болон гэрээний нөхцөлийн дагуу захиалагчид ирүүлнэ.
- 40.2. Гүйцэтгэлийн баталгааг:
- (а) тендерт оролцогчийн сонголтоор Монгол улсад байрладаг банкаар буюу гадаадын банкны Монгол улсад байрладаг харилцагч банкаар,
эсхүл
 - (б) захиалагчийн хүлээн зөвшөөрсөн гадаадын банкаар гаргуулна.
- 40.3. Шалгарсан тендерт оролцогч ТООЗ-ны 40.1-д заасан шаардлагыг биелүүлээгүй нь гэрээ байгуулах эрхийг хүчингүй болгох, тендерийн баталгааг гүйцэтгүүлэх хангалттай үндэслэл болно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

Тухайн тендер шалгаруулалтын үр дүнд гүйцэтгэх ажлын талаарх дор дурдсан өгөгдөл нь ТӨӨЗ-ны холбогдох зүйл, заалтад нэмэлт мэдээлэл оруулах, эсхүл өөрчлөх зорилготой. Хэрэв ТӨӨЗ-ны зүйл заалттай зөрчилдвөл энэхүү ТШӨХ-д дурдсан мэдээллийг зөв гэж үзнэ.

| | |
|--|---|
| ТӨӨЗ-ны холбогдох заалт | А. Ерөнхий зүйл |
| ТӨӨЗ 1.1 | Захиалагч нь: <i>ДЦС-3 ТӨХК-ийн Засвар хяналтын алба. ХУД 3-р хороо</i> |
| ТӨӨЗ 1.1 | Нээлттэй тендер шалгаруулалтын нэр: <i>БКЗ-75-39фб маркийн Зуух №6-н их засварын ажил. “Засвар-02. 2020” дугаар бүхий тендер</i> |
| ТӨӨЗ 1.2 | Ажил гүйцэтгэж дуусах хугацаа нь: <i>Ажлын талбай ашиглуулж эхэлснээс хойш хуанлийн 90 хоног</i> |
| ТӨӨЗ 1.3 | Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <i>Нэг багц тендер.</i> |
| ТӨӨЗ 2.1 | Санхүүжилтийн эх үүсвэр нь: <i>Өөрийн хөрөнгө</i> |
| ТӨӨЗ 4.4.(в) | Уг ажлыг гүйцэтгэхэд тусгай зөвшөөрөл зайлшгүй шаардлагатай эсэх: <i>“туйм”</i> <i>Эрчим хүчний яам:</i> <i>03.3.3. Зуухны угсралт засвар, түүний туршилт тохируулга, дагалдах ажил 350 - 450⁰С, 40-80кгх/см² болон түүнээс дээш</i> |
| ТӨӨЗ 5.2 | Тендерт оролцогч гэрээг хэрэгжүүлэх чадвартайг нотлохын тулд захиалагч дараахнэмэлт нотлох баримтыг тендерийн хамт ирүүлэх: <ul style="list-style-type: none">• <i>Нийслэлийн шүүх, эрх бүхий байгууллагуудын тодорхойлолт</i>• <i>Нийлүүлэх бараа материалыг үйлдвэрлэгч газрын сертификат, техникийн тодорхойлолт, үзүүлэлтүүд</i>• <i>Үйлдвэрлэгчийн итгэмжлэл</i> <i>Нийгмийн даатгалын НД7, НД8 маягтын хуулбар /нотариатаар баталгаажуулсан/</i> |
| ТӨӨЗ 5.2.(б) | Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: <i>Сүүлийн 2 жил</i> Санхүүгийн тайланг аудитаар баталгаажуулсан байх шаардлагатай эсэх: <i>“шаардлагатай”</i> |

| <p>ТӨӨЗ 5.2 (г)</p> | <p>Хийж гүйцэтгэсэн ажлын нийт мөнгөн дүнг жил жилээр харуулсан жагсаалт ирүүлэх шаардлагатай жилийн тоо: Сүүлийн 3 жил</p> <p>2017, 2018, 2019 онд хийж гүйцэтгэсэн ажлын жагсаалтыг ирүүлнэ. /доорхи загварын дагуу/</p> <table border="1" data-bbox="472 327 1442 640"> <thead> <tr> <th data-bbox="472 327 544 510">№</th> <th data-bbox="544 327 836 510">Гэрээний нэр дугаар</th> <th data-bbox="836 327 1059 510">Захиалагч байгууллагын нэр, хаяг, холбоо барих утас/факс</th> <th data-bbox="1059 327 1267 510">Төсөвт өртөг</th> <th data-bbox="1267 327 1442 510">Дууссан эсвэл дуусах хугацаа</th> </tr> </thead> <tbody> <tr> <td data-bbox="472 510 544 577">1</td> <td data-bbox="544 510 836 577"></td> <td data-bbox="836 510 1059 577"></td> <td data-bbox="1059 510 1267 577"></td> <td data-bbox="1267 510 1442 577"></td> </tr> <tr> <td data-bbox="472 577 544 640"></td> <td data-bbox="544 577 836 640" style="text-align: center;">Дүн</td> <td data-bbox="836 577 1059 640"></td> <td data-bbox="1059 577 1267 640"></td> <td data-bbox="1267 577 1442 640"></td> </tr> </tbody> </table> | № | Гэрээний нэр дугаар | Захиалагч байгууллагын нэр, хаяг, холбоо барих утас/факс | Төсөвт өртөг | Дууссан эсвэл дуусах хугацаа | 1 | | | | | | Дүн | | | |
|----------------------------|---|--|---------------------|--|--------------|------------------------------|---|--|--|--|--|--|-----|--|--|--|
| № | Гэрээний нэр дугаар | Захиалагч байгууллагын нэр, хаяг, холбоо барих утас/факс | Төсөвт өртөг | Дууссан эсвэл дуусах хугацаа | | | | | | | | | | | | |
| 1 | | | | | | | | | | | | | | | | |
| | Дүн | | | | | | | | | | | | | | | |
| <p>ТӨӨЗ 5.2 (д)</p> | <p>Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын талаарх мэдээлэл ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 3 жил. Ижил төстэй ажилд ЭХЯ-ны 3.3.3 ба түүнээс дээш бүхий заалтанд тохирсон ажлыг 1-ээс доошгүй удаа үндсэн гүйцэтгэгчээр ажилласан байх.</p> | | | | | | | | | | | | | | | |
| <p>ТӨӨЗ 5.2 (к)</p> | <p>Тендерт оролцогч туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлж болох хувь хэмжээ нь гэрээний үнийн дүнгийн 10 хүртэл хувь байна. Үүнээс дээш хувийг гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэх бол түншлэлийн гэрээ байгуулж тендерийн хамт ирүүлэх ба ТӨӨЗ-нд дурдсан бусад шалгуурыг хангасан байх шаардлагатай.</p> | | | | | | | | | | | | | | | |
| <p>ТӨӨЗ 5.3 (а)</p> | <p>Борлуулалтын хэмжээ:</p> <p>Сүүлийн хоёр жилийн борлуулалтын орлогын дундаж нь 600,0 сая төгрөгөөс дээш байх.</p> | | | | | | | | | | | | | | | |
| <p>ТӨӨЗ 5.3 (б)</p> | <p>Ижил төстэй ажлыг ядаж нэг удаа гүйцэтгэсэн байвал зохих хугацаа:</p> <p style="text-align: center;">Сүүлийн 3-н жил. (2017, 2018, 2019).</p> <ul style="list-style-type: none"> • Сүүлийн хоёр жилийн дундаж 500,0 сая төгрөгийн үнийн дүнтэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн байх. • Ижил төстэй ажилд зөвхөн эрчим хүчний яамнаас олгодог 3.3.3 түүнээс дээш заалтуудаар зөвшөөрөгдсөн ажлуудыг тооцно. | | | | | | | | | | | | | | | |
| <p>ТӨӨЗ 5.3 (в)</p> | <p>Тендерт оролцогч гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай үндсэн тоног төхөөрөмж, машин механизмууд:</p> <p>Ажлын материал, сэлбэг зөөх ачааны машинтай байх, (нотлох баримтыг хавсаргах)</p> <p>Хийцийн ажил гүйцэтгэх труба матагч, лист хуйлах, нугалах гэх мэт металл хийц бэлтгэх тоног төхөөрөмжтэй байх, /байхгүй бол уг ажлыг гүйцэтгэх чадвар бүхий этгээдтэй уг ажлыг гүйцэтгүүлэхээр хийсэн гэрээтэй байх/,</p> <p>380В-ын гагнуурын аппарат, металл огтлох, зүсэх төхөөрөмж 2-оос доошгүй комплект байх, өнгөлгөөний гар машин, суурин таслагч, гар таль, оосорлох, татах татлага гэх мэт багаж уг ажлыг гүйцэтгэхэд хүрэлцэхүйц байх.</p> | | | | | | | | | | | | | | | |

| ТӨЭЗ 5.3 (г) | <p>Ерөнхий инженер нь гэрээнд заасан ажилтай төрөл, үнийн дүнгээрээ дүйцэх ажил дээр ажилласан туршлагатай байх хугацаа:</p> <p style="text-align: center;">5 жил</p> <p>Түүний дотроос гэрээг хариуцаж ажилласан туршлагатай байх хугацаа:</p> <p style="text-align: center;">3 жил</p> <p>Ажлын талбайн удирдагч /хариуцлагатай удирдагч/, ажил гүйцэтгэгч нь бие дааж зуухны үндсэн хэсэг, тээрэм, эргэх механизмийн их засвар хийсэн туршлага хавсаргах.</p> <table border="1" data-bbox="472 495 1442 1137"> <thead> <tr> <th>№</th> <th>Албан тушаал</th> <th>Хүний тоо</th> <th>Ажлын туршлага жилээр</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1</td> <td>Ерөнхий инженер буюу төслийн ерөнхий менежер</td> <td>1</td> <td>5</td> </tr> <tr> <td>2</td> <td>Эргэх механизмийн инженер</td> <td>1</td> <td>3</td> </tr> <tr> <td>3</td> <td>Халах гадаргуу, хаалт арматурын инженер, мастер</td> <td>1</td> <td>3</td> </tr> <tr> <td>4</td> <td>Өрлөг дулаалгын инженер</td> <td>1</td> <td>3</td> </tr> <tr> <td>5</td> <td>Халах гадаргуу, хаалт арматурын 5,6-р зэрэгтэй засварчин</td> <td>5</td> <td>5</td> </tr> <tr> <td>6</td> <td>5-с дээш зэрэгтэй, 2А-аас дээш категортой гагнуурчин</td> <td>4</td> <td>5</td> </tr> <tr> <td>7</td> <td>Өрлөг дулаалагч, нимгэн төмөрчин 5, 6 зэрэгтэй ажилтан</td> <td>2</td> <td>5</td> </tr> <tr> <td>8</td> <td>ХАБЭА хариуцсан инженер</td> <td>1</td> <td>3</td> </tr> <tr> <td>9</td> <td>Оосорлогч дохиочин</td> <td>2</td> <td>3</td> </tr> <tr> <td>10</td> <td>Эргэх механизмийн 5,6-р зэрэгтэй засварчин</td> <td>2</td> <td>5</td> </tr> </tbody> </table> <p><i>Дээрх хүмүүсийг оролцуулаад нийт ажиллах хүч 30-с доошгүй байх. Нийт 20 хүнээс багагүй тоогоор нийгмийн даатгалын шимтгэл 6 сараас доошгүй хугацаанд төлсөн талаарх баримт маягтын дагуу хавсаргасан байх. Гагнуурчны үнэмлэхний баталгаажуулалт, сунгалтанд зөвхөн Эрчим хүчний яамны харъяа байгууллагын эрх бүхий лабораториуд болон Монголын гагнуурын нийгэмлэгийн баталгаажуулалт сунгалтыг тооцно. Тендерт нэр ирүүлсэн эрх бүхий гагнуурчдаас захиалагч тал гагнуурын онолын болон дадлагын шалгалтыг авч зэрэг категорийг баталгаажуулсаны дараа тендерийг үнэлнэ. Гагнуурчин нь 1 жилээс доошгүй хугацаанд тухайн компани дээр Нийгмийн Даатгалын шимтгэл төлсөн байх</i></p> | № | Албан тушаал | Хүний тоо | Ажлын туршлага жилээр | 1 | Ерөнхий инженер буюу төслийн ерөнхий менежер | 1 | 5 | 2 | Эргэх механизмийн инженер | 1 | 3 | 3 | Халах гадаргуу, хаалт арматурын инженер, мастер | 1 | 3 | 4 | Өрлөг дулаалгын инженер | 1 | 3 | 5 | Халах гадаргуу, хаалт арматурын 5,6-р зэрэгтэй засварчин | 5 | 5 | 6 | 5-с дээш зэрэгтэй, 2А-аас дээш категортой гагнуурчин | 4 | 5 | 7 | Өрлөг дулаалагч, нимгэн төмөрчин 5, 6 зэрэгтэй ажилтан | 2 | 5 | 8 | ХАБЭА хариуцсан инженер | 1 | 3 | 9 | Оосорлогч дохиочин | 2 | 3 | 10 | Эргэх механизмийн 5,6-р зэрэгтэй засварчин | 2 | 5 |
|---------------------|--|-----------|-----------------------|-----------|-----------------------|---|--|---|---|---|---------------------------|---|---|---|---|---|---|---|-------------------------|---|---|---|--|---|---|---|--|---|---|---|--|---|---|---|-------------------------|---|---|---|--------------------|---|---|----|--|---|---|
| № | Албан тушаал | Хүний тоо | Ажлын туршлага жилээр | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 1 | Ерөнхий инженер буюу төслийн ерөнхий менежер | 1 | 5 | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 2 | Эргэх механизмийн инженер | 1 | 3 | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 3 | Халах гадаргуу, хаалт арматурын инженер, мастер | 1 | 3 | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 4 | Өрлөг дулаалгын инженер | 1 | 3 | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 5 | Халах гадаргуу, хаалт арматурын 5,6-р зэрэгтэй засварчин | 5 | 5 | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 6 | 5-с дээш зэрэгтэй, 2А-аас дээш категортой гагнуурчин | 4 | 5 | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 7 | Өрлөг дулаалагч, нимгэн төмөрчин 5, 6 зэрэгтэй ажилтан | 2 | 5 | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 8 | ХАБЭА хариуцсан инженер | 1 | 3 | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 9 | Оосорлогч дохиочин | 2 | 3 | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| 10 | Эргэх механизмийн 5,6-р зэрэгтэй засварчин | 2 | 5 | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| ТӨЭЗ 5.3 (д) | <p>Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн⁷ нийт дүн: 300,0 сая төгрөг (нотлох баримт хавсаргах)</p> | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| ТӨЭЗ 6.1 | <p>Түншлэлийн гишүүд дараах нэмэлт шаардлагыг хангасан байх ёстой. Үүнд:</p> <p>Түншлэлийн хувьд чадварын доод шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхийг тодорхойлохийн тулд түншлэлийн гишүүн тус бүрийн үзүүлэлтийг хооронд нь нэмнэ. Гэхдээ гишүүн тус бүр 5.3(а), болон 5.3(д)-д заасан чадварын доод шалгуур үзүүлэлтийн доод тал нь 25 хувийг, төлөөлөх эрх бүхий гишүүн доод тал нь 40 хувийг хангасан байна.</p> | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |

⁷ Авах боломжтой зээл гэдэгт зээлжих баталгаажсан эрх, харилцагч банкнаас зээл олгох албан мэдэгдэл зэрэг байж болно.

| Б. Тендерийн баримт бичиг | |
|----------------------------------|---|
| ТӨӨЗ 10.1 | <p>Захиалагчаас тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга авах хаяг: <i>Тендерт оролцогчид тодруулга хүссэн тохиолдолд доорх хаягаар мэдээлэл авах шаардлагатай тул анхаарна уу.</i> www.tender.gov.mn</p> <p>Тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах хүсэлт хүлээн авах хугацаа хуанлийн тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө ажлын 5 хоногоос багагүй байна.</p> |
| ТӨӨЗ 11.1 | <p>Тендер ирүүлэхийн өмнөх уулзалтыг зохион байгуулах эсэх: “Үгүй”</p> |
| В. Тендер бэлтгэх | |
| ТӨӨЗ 14.1 (ж) | <p>Тендерт оролцогч дараах нэмэлт материалуудыг өөрийн тендерт ирүүлнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. <i>Үе шатны ажлын хуваарь</i> 2. <i>Ажлыг гүйцэтгэх нарийвчилсан хугацааны график</i> 3. <i>ТӨӨЗ-ны 4.2.1-ээс 4.2.8 заалтыг зөрчөөгүй болохыг нотолсон баримт</i> 4. <i>ТӨӨЗ-ны 5.1, 5.2, 5.3 заалтыг хангасан болохыг нотлох баримт</i> 5. <i>Тендерийн гэрээний тусгай нөхцөл, гэрээний маягт, техникийн даалгаварыг хүлээн зөвшөөрсөн албан бичиг</i> 6. <i>Үе шатны ажлын хуваарьт заасан ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай сэлбэг, материалыг, жагсаалтаар үнийг бүрэн тооцож ирүүлнэ. Шаардлагатай сэлбэг материалын жагсаалтанд ажлыг бүрэн хэмжээгээр гүйцэтгэхэд хангалттай тоо хэмжээгээр тусгагдаагүй, орхигдуулсан тохиолдолд орхигдсон сэлбэг материалын үнийг тооцон үнэлгээнд харгалзан үзнэ.</i> |
| ТӨӨЗ 16.1 | <p>Хувилбарт тендер ирүүлэхийг “Зөвшөөрөхгүй”</p> |
| ТӨӨЗ 17.8 | <p>Тендерт оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад “тохируулахгүй тогтмол байна.”</p> |
| ТӨӨЗ 18.1 | <p>Тендерийн валют: Төгрөг байна.</p> |
| ТӨӨЗ 20.1 | <p>Тендер нээснээс хойш 30 хоногийн туршид хүчинтэй байна.</p> |
| ТӨӨЗ 21 | <p>Тендерийн баталгааны үнийн дүн: 11 520 000 төгрөг байна Хүчинтэй байх хугацаа: 2020 он 05 сар 08 өдөр</p> |
| ТӨӨЗ 22.1 | <p>Тендерийн эх хувиас гадна ирүүлэх хуулбар хувийн тоо: “шаардлагагүй”</p> |
| Г. Тендер ирүүлэх | |

| | |
|---|---|
| <p>ТӨӨЗ 23.3 (б)</p> | <p>Захиалагч тендерүүдийг хүлээн авах хаяг нь: Тендер хүлээн авах этгээд: <i>Худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn) хаягаар ААН-үүд хувийн нууцлалын кодоо ашиглан нээгдэх, цахим хэлбэрээр (pdf)-д хөрвүүлэн илгээнэ. Цахим тендер зохион байгуулах журмын дагуу тендерт оролцох хураамж 50 000 төгрөгийг www.tender.gov.mn-ээр банкны меркантын систем ашиглан төлнө.</i> Байгууллагын хаяг: ДЦС-3 ТӨХК өөрийн байр Аймаг, хот: Улаанбаатар хот, ХУД, 3-р хороо, Ажилчины гудамж Улс: Монгол Улс</p> |
| <p>ТӨӨЗ 23.3 (в)</p> | <p>Тендерт оролцогч нь тендерийн иж бүрдэл, баримт бичгийг бэлтгэн цахим хэлбэрт (adobe PDF) шилжүүлэн, цахим хэлбэрээр ирүүлнэ. Нэр, ялгах дугаарыг гаргацтай тэмдэглэнэ: БКЗ-75-39фб маркийн Зуух №6-н их засварын ажил, “ЗАСВАР-02. 2020”</p> |
| <p>ТӨӨЗ 24.1</p> | <p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: Огноо: 2020 оны 03 дугаар сарын 11 - ний өдөр Цаг: 10 цаг 00 минут</p> |
| <p>Д. Тендерийг нээх, үнэлэх</p> | |
| <p>ТӨӨЗ 27.1</p> | <p>Тендерийн нээлт хийх газрын хаяг нь дор өгөгдөв. Үүнд: Байшин, гудамжны нэр: ДЦС-3 ТӨХК өөрийн байр Давхар болон өрөөний дугаар: Захиргааны 2-р давхар, Зөвлөгөөний танхим Аймаг, хот: ХУД 3-р хороо, УБ хот Тендерийн нээлт хийх огноо, цаг нь: Огноо: 2020 оны 03 дугаар сарын 11 - ний өдөр Цаг: 10 цаг 30 минут</p> |
| <p>ТӨӨЗ 33.1</p> | <p>Дотоодын давуу эрхийн зөрүү: “тооцно”</p> |
| <p>ТӨӨЗ 40.1</p> | <p>Гэрээний маягтууд буюу VII бүлэг дэх тохирох маягтын дагуу Гүйцэтгэлийн баталгааг гаргуулж гэрээнд гарын үсэг зурахаас өмнө захиалагчид ирүүлэх шаардлагатай. Гүйцэтгэлийн баталгааны хэмжээ буюу мөнгө дүн нь гэрээний үнийн дүнгийн 5 хувьтай тэнцүү байна.</p> |

ГУРАВДУГААР БҮЛЭГ.

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН МАЯГТ

Тендерийн маягт, Чадварын мэдээлэл ирүүлэх маягт,
Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл,

Тендершалгаруулалтын маягтыг бөглөх санамж

Тендерт оролцогч тендерийн баримт бичгийн шаардлагын дагуу тендерийн маягт, энэ бүлэгт заасан маягтаар гаргасан тендерийн баталгааны хамт ирүүлнэ.

Шалгарсан тендерт оролцогч гүйцэтгэлийн баталгаа, урьдчилгаа төлбөрийн баталгааг энэ бүлэгт заасан маягтаар ирүүлэх үүрэгтэй. Урьдчилгаа төлбөрийн баталгааг ирүүлэх шаардлагагүй бол урьдчилгаа төлбөрийн баталгааны маягтыг тендерийн баримт бичигт хавсаргахгүй.

ТЕНДЕРИЙН МАЯГТ

МАЯГТ№ ТШМ-1

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендерийн үнийг тооцоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.

Гэрээний төлбөрийг дараах валютаар авна. Үүнд:

| № | Валютын нэр | Тус валютаар төлөх хувь | Гадаад валютын ханш /гадаад валютын нэгж хэдэн төгрөгтэй тэнцэх/ | Шаардагдах гадаад валютын дүн |
|-----|-------------|-------------------------|--|-------------------------------|
| (a) | | | | |
| (б) | | | | |

Шаардагдах урьдчилгаа төлбөр:

| | Валютын нэр | Валютын дүн |
|-----|-------------|-------------|
| (a) | | |
| (б) | | |

2. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер нээснээс [тоо] хоногийн хугацаанд хүчинтэй байна.
3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
4. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Тендерт оролцогчийн нэр: _____

Эрх бүхий этгээдийн гарын үсэг, тамга: _____

Албан тушаал, нэр: _____

Хаяг: _____

ЧАДВАРЫН МЭДЭЭЛЭЛ

Чадварын мэдээллийг бөглөх санамж

Гэрээг хэрэгжүүлэх чадвартайгаа нотлох, эсхүл урьдчилсан сонголтод ирүүлсэн мэдээлэлд орсон өөрчлөлтийг тодотгох зорилгоор ТООЗ-ны 5дугаар зүйлд заасны дагуу тендерт оролцогч дараах мэдээллийг бөглөж ирүүлнэ. Эдгээр мэдээлэл гэрээний хэсэг болохгүй. Шаардлагатай бол нэмэлт хуудас хэрэглэнэ. Хавсаргасан бичиг баримт нь тендерийг бэлдсэн хэлнээс өөр хэл дээр бол түүнийг орчуулсан байх шаардлагатай. Тендерт оролцогч урьдчилсан сонголтод оролцсон бол зөвхөн өөрчлөгдсөн мэдээллээ бөглөж ирүүлнэ.

- 1. Тендерт оролцогч болон түншлэлийн гишүүн бүр**
- 1.1. Тендерт оролцогч хуулийн этгээд болох талаар баталгаа болон тусгай зөвшөөрөл: **[хуулбарыг хавсаргах]**
- Бүртгүүлсэн газар: **[бөглөх]**
- Бизнесийн үйл ажиллагааны үндсэн хаяг: **[бөглөх]**
- Тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурсан этгээдийн итгэмжлэл: **[хавсаргах]**
- 1.2. Сүүлийн **[тоо]** жилийн хугацаанд хийж гүйцэтгэсэн барилгын ажлын нийт мөнгөн дүнг жил, жилээр жагсаах: **[бөглөх]**
- 1.3. Ерөнхий гүйцэтгэгчээр сүүлийн **[тоо]** жилийн хугацаанд хийж гүйцэтгэсэн төрөл болон хэмжээгээр ижил төстэй ажил ба гэрээний үнийн дүнг дээрх 1.2-т заасан валютаар илэрхийлж доорх хүснэгтэд бичнэ. Түүнчлэн хийхээр төлөвлөсөн болон одоо хийж буй ажил, тэдгээрийг дуусгахаар төлөвлөж буй хугацааг жагсаах.

| Төслийн нэр ба улс | Захиалагч, үйлчлүүлэгчийн нэр, холбоо барих ажилтан | Гүйцэтгэсэн ажлын төрөл, дууссан он | Гэрээний үнэ |
|--------------------|---|-------------------------------------|--------------|
| (а) | | | |
| (б) | | | |

- 1.4. Гэрээг гүйцэтгэхэд санал болгож буй барилгын үндсэн машин механизм, тоног төхөөрөмжийн нэр төрлийн талаарх мэдээллийг доорх хүснэгтээр ирүүлнэ. Мөн ТООЗ-ны 5.2(е)-г анхаар.

| Тоног төхөөрөмжийн нэр төрөл | Тодорхойлолт, хаана үйлдвэрлэсэн, ашиглагдсан хугацаа (жилээр) | Ашиглалтын байдал (шинэ, сайн, хуучин), ба тоо ширхэг | Өөрийн, түрээслэх, эсхүл худалдаж авах (хаанаас?) |
|------------------------------|--|---|---|
| (а) | | | |
| (б) | | | |

- 1.5. Гэрээнд санал болгож буй удирдах болон техникийн голлох мэргэжилтний чадвар, туршлага. Намтрыг хавсаргана. Мөн ТООЗ-ны 5.3(г) болон гэрээний ерөнхий нөхцөлийн 9.1-ийг анхаар.

| Албан тушаал | Нэр | Ажилласан жил (нийт) | Санал болгож буй албан тушаалтай ижил албан тушаалд ажилласан жил |
|--------------|-----|----------------------|---|
| | | | |

| | | | |
|-----|--|--|--|
| (a) | | | |
| (б) | | | |

1.6. Санал болгож буй туслан гүйцэтгэгч. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг анхаар.

| Ямар ажил гүйцэтгэх | Туслан гүйцэтгэх гэрээний үнэ | Туслан гүйцэтгэгч (нэр, хаяг) | Ижил төстэй ажлын туршлага | Шийдэгдсэн байдал |
|---------------------|-------------------------------|-------------------------------|----------------------------|-------------------|
| (a) | | | | |
| (б) | | | | |

1.7. Санхүүгийн чадавхийг харуулах аудитаар баталгаажуулсан сүүлийн [moo] жилийн санхүүгийн тайлан, ашиг орлого, алдагдлын болон санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн тайлан, дүгнэлтийн хамт. Дор жагсааж хувийг хавсаргана.

1.8. Чадварын шаардлагыг хангахад шаардагдаж болох санхүүгийн эх үүсвэрийн нотолгоо: бэлэн мөнгө, зээл гэх мэт. Дор жагсааж үндсэн бичиг баримтын хувийг хавсаргана.

1.9. Тендерт оролцогчийн харилцагч банкны нэр, хаяг болон утас, факсын дугаар.

1.10. Тендерт оролцогчийн одоогийн ба сүүлийн [too] жилийн хугацаанд оролцсон аливаа шүүхийн зарга, маргааны талууд ба нэхэмжлэлийн мөнгөн дүн, шийдэгдсэн байдал.

| Нөгөө тал(ууд) | Маргааны шалтгаан | Нэхэмжлэлийн мөнгөн дүн | Шийдэгдсэн байдал |
|----------------|-------------------|-------------------------|-------------------|
| (a) | | | |
| (б) | | | |

1.11. Тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны 4.2-т хамрагдахгүй бөгөөд эрх бүхий тухай мэдэгдэл.

1.12. Санал болгож буй ажлын хөтөлбөр (ажлын арга барил ба хуваарь). Тендерийн баримт бичгийн шаардлагыг хангахуйц тодорхойлолт, зураг болон бүдүүвч шаардлагатай бол.

2. Түншлэл

2.1. Чадварын мэдээллийн 1.1-1.11-д дурдсан бүх мэдээллийг түншлэлийн гишүүн тус бүрээр гаргаж ирүүлнэ.

2.2. Чадварын мэдээллийн 1.12-т дурдсан мэдээллийг түншлэлийн хувьд гаргаж ирүүлнэ.

2.3. Түншлэлийн нэрийн өмнөөс тендерт гарын үсэг зурах эрх бүхий этгээдийн итгэмжлэлийг хавсаргана.

2.4. Дор дурдсан шаардлагыг хангасан түншлэлийн бүх гишүүдийн хооронд байгуулсан гэрээг хавсаргана. Үүнд:

2.5.

(a) гэрээний нөхцөлийн дагуу гэрээг хэрэгжүүлэхэд бүх гишүүд хамтран болон тус тусдаа хүлээх хариуцлагыг тодорхой заасан байх;

(б) түншлэлийн аль нэг болон бүх гишүүдийн нэрийн өмнөөс үүрэг хүлээх, зааварчилгаа хүлээн авахад тэдгээрийг төлөөлөх эрх бүхий нэг гишүүн томилсон байх;

(в) нийт гэрээний гүйцэтгэл, түүний дотор төлбөрийг зөвхөн төлөөлөх эрх бүхий гишүүнтэй тооцох.

**ТЕНДЕРИЙН БАТАЛГААНЫ МАЯГТ
(БАНКНЫ БАТАЛГАА)*****[Захиалагч байгууллагын нэр]***

[Тендерт оролцогчийн нэр] (цаашид “Тендерт оролцогч” гэх) нь *[Тендер шалгаруулалтын нэр]* бараа нийлүүлэхээр тендер (цаашид “Тендер” гэх) санал болгосонтой ХОЛБОГДУУЛАН,

Энэхүү баталгаагаар *[Банкны нэр]* (цаашид “Банк” гэх) нь *[Захиалагчийн нэр]* (цаашид “захиалагч” гэх)-ийн өмнө нийт *[мөнгөн дүн]*-ийн төлбөр хийх үүрэг хүлээж баталгаа гаргаж байна.

Төлбөр хийх үүрэг нь дор дурдсан нөхцөлд үүснэ. Үүнд:

- (1) тендерийг нээсний дараа тендерийн маягтад заасан тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө тендерт оролцогч өөрийн тендерийг буцааж авсан;
- (2) захиалагч тендер хүчинтэй байх хугацаанд багтаж гэрээ байгуулах эрх олгосон үед тендерт оролцогч:
 - (а) тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны дагуу гэрээг байгуулаагүй бол;
 - (б) тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны дагуу гүйцэтгэлийн баталгааг ирүүлээгүй бол;
 - (в) тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны дагуу хийгдсэн тендерийн үнийн алдааны залруулгыг хүлээн зөвшөөрөөгүй бол.
- (3) төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тендерт оролцогчийн гаргасан гомдлыг үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн.

Энд тодорхойлогдсон нөхцөлүүдийн аль нэг нь үүссэнийг дурдаж төлбөр хийх тухай захиалагчийн анхны шаардлагыг бичгээр хүлээн авсан даруй төлбөрийг үл маргалдах журмаар хийнэ. Төлбөр төлөх шаардлагын хэмжээ нь дээр заасан мөнгөн дүнгээс хэтрэхгүй ба (3)-т заасан нөхцөл үүссэн тохиолдолд 20 сая хүртэл төгрөг байна.

Энэхүү баталгаа нь **[огноог оруул]** өдрийг дуустал хүчинтэй. Захиалагч баталгааатай холбогдсон аливаа шаардлагыг энэ хугацаанд багтаж банкинд мэдэгдэх ёстой.

Та бүхнийг хүндэтгэсэн,

Банкны эрх бүхий албан тушаалтны гарын үсэг:

Албан тушаал, нэр:

Банкны тамга:

Огноо:

Хаяг:

**ТЕНДЕРИЙН БАТАЛГААНЫ МАЯГТ
(ЗАСГИЙН ГАЗРЫН БОНДЫН БАТАЛГАА)****[Захиалагч байгууллагын нэр]**

[Тендерт оролцогчийн нэр] (цаашид “Тендерт оролцогч” гэх) нь [Тендер шалгаруулалтын нэр] бараа нийлүүлэхээр тендер (цаашид “Тендер” гэх) санал болгосонтой ХОЛБОГДУУЛАН,

Энэхүү баталгаагаар [Хөрөнгийн бирж] (цаашид “Бирж” гэх) нь [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх)-ийн өмнө нийт [мөнгөн дүн]-ийн төлбөр хийх үүрэг хүлээж тендерт оролцогчийн засгийн газрын бондыг үндэслэн баталгаа гаргаж байна.

Төлбөр хийх үүрэг нь дор дурдсан нөхцөлд үүснэ. Үүнд:

- (1) тендерийг нээсний дараа тендерийн маягтад заасан тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө тендерт оролцогч өөрийн тендерийг буцааж авсан;
- (2) захиалагч тендер хүчинтэй байх хугацаанд багтаж гэрээ байгуулах эрх олгосон үед тендерт оролцогч:
 - (а) тендерт оролцогчид өгөх зааварчилгааны дагуу гэрээг байгуулаагүй бол;
 - (б) тендерт оролцогчид өгөх зааварчилгааны дагуу гүйцэтгэлийн баталгааг ирүүлээгүй бол;
 - (в) тендерт оролцогчид өгөх зааварчилгааны дагуу хийгдсэн тендерийн үнийн алдааны залруулгыг хүлээн зөвшөөрөөгүй бол.
- (3) төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тендерт оролцогчийн гаргасан гомдлыг үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн.

Энд тодорхойлогдсон нөхцөлүүдийн аль нэг нь үүссэнийг дурдаж төлбөр хийх тухай захиалагчийн анхны шаардлагыг бичгээр хүлээн авсан даруй Засгийн газрын бондыг үл маргалдах журмаар шилжүүлнэ. Засгийн газрын бонд шилжүүлэх шаардлагын хэмжээ нь дээр заасан мөнгөн дүнгээс хэтрэхгүй ба (3)-т заасан нөхцөл үүссэн тохиолдолд 20 сая хүртэл төгрөг байна.

Энэхүү баталгаа нь **[огноог оруул]** өдрийг дуустал хүчинтэй. Захиалагч баталгааатай холбогдсон аливаа шаардлагыг энэ хугацаанд багтаж биржид мэдэгдэх ёстой.

Та бүхнийг хүндэтгэсэн,

Банк/Биржийн эрх бүхий албан тушаалтны гарын үсэг:

Албан тушаал, нэр:

Банк/Биржийнтамга

Огноо:

Хаяг:

ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ЭРХ ОЛГОХ ТУХАЙ МЭДЭГДЭЛ
(Захиалагчийн албан бичгийн хэвлэмэл хуудсан дээр бичнэ)

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэлийг бичих санамж

Тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны дугаар зүйлд заасны дагуу гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл нь хэлцэл хийгдсэн гэж үзэх үндэслэл болно. Захиалагч энэхүү гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг зөвхөн шалгарсан тендерт оролцогчид илгээнэ.

[огноо]

[Гүйцэтгэгчийн нэр]-ийн дарга _____ Танаа,

Гэрээ байгуулах эрх олгох тухай

[Гэрээний тусгай нөхцөлд заасан тендер шалгаруулалт/ гэрээний нэр ба дугаар]-ыг [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] гүйцэтгэхээр [огноо]-ндирүүлсэн танай тендерийг тендерт оролцогчдод өгөх зааварчилгаанд тусгасны дагуу залруулга, тохируулгахийсэн байдлаар манай байгууллага хүлээн зөвшөөрснийг мэдэгдье.

Энэхүү мэдэгдлийг хүлээн авснаас хойш **[моо]** хоногийн дотор гэрээний маягтад гарын үсэг зурж ирүүлнэ үү.

Шаардлага хангасан гүйцэтгэлийн баталгааг энэхүү мэдэгдэл хүлээн авснаас хойш 21 хоногийн дотор ирүүлээгүй нь гэрээ байгуулах эрхийг хүчингүй болгох үндэслэл болно.

Гэрээний маягт, нөхцөлүүдийг хавсаргав.

Захиалагч байгууллагын нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

ДЦС-3 ТӨХК-ны ДДЗ цехийн БКЗ-75-39фб маягийн ЗУУХ №6-ийн их засвараар хийх ажлын техникийн тодорхойлолт.

Зуух №5-ийн их засварын ажил гүйцэтгэхдээ тендерийн материалын 4-р бүлэгт заагдсан үе шатны ажлын хуваарьт тусгагдсан бүх ажлыг узель зангилаа бүрд бүрэн хэмжээгээр чанартай гүйцэтгэнэ. Ажлын явцад ажлын эзэлхүүнээс нэмэгдэх хасагдах зүйл гарч болно. Гарсан нэмэгдэл ажлыг магадлашгүй ажлын зардлаар хийнэ. Магадлашгүй ажлын зардал болон НӨАТ-г гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарьт тусгаж өгнө. Захиалагч нэмэлт ажлын төсөв зардал гэж тусдаа гаргахгүй.

Зуухны засварын ажлыг гүйцэтгэхдээ засварын технологиудыг чанд баримталж ажиллах, шаардлагатай үед ЗХА-ны мэргэжилтэнүүдтэй зөвлөлдөж тусгай технологи гаргаж түүний дагуу засварын ажил гүйцэтгэх ёстой. Дур мэдэн ямар нэг өөрчлөлт, технологи хэрэглэхгүй байх.

Захиалагчаас засварын технологийн мөрдөлт, засварын чанар, материал сэлбэг зарцуулалт, ажлын гүйцэтгэлд төслийн менежер болон захилагчийн мэргэжлийн инженер, мастерууд, МСГЛ-ийн мэргэжилтнүүд хяналт тавьж ажиллана.

Засварын ажил гүйцэтгэх байгууллагад буюу гүйцэтгэгчид тавигдах тендерийн ерөнхий шаарлага, тендерийн нөхцөлүүд, ХАБЭА-н шаардлага, засварын дараа тавигдах техникийн ерөнхий шаардлагуудыг заалт бүрээр бүрэн биелүүлнэ. Засварын ажилд үнэлгээ өгөхдөө тендерт тавигдсан шаардлага нөхцөлүүдийг биелүүлсэн байдлыг заалт бүрээр нь үнэлэж дундаж үнэлгээг гаргана.

ГҮЙЦЭТГЭГЧИД ТАВИГДАХ ТЕНДЕРИЙН ШААРДЛАГА, ТЕНДЕРИЙН НӨХЦӨЛҮҮД

ТЕНДЕРИЙН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

1. Энэхүү засварын ажлыг хуанлийн 90 хоногт бүрэн хэмжээгээр хийсэн байна.
2. Их засварын ажлыг хийж гүйцэтгэхэд шаардагдах хийц, эд ангиуд, тэдгээрийг үйлдвэрлэх, нийлүүлэх, техникийн зураг, техникийн детальчилсан зураг гаргах, зорлого хийх, матах, өрөмдөх, хуйлах ажлын хөлс, болон бусад зардлыг гүйцэтгэгч бүрэн хариуцах бөгөөд зардлуудыг сонгон шалгаруулалтын материалд тусгасан байвал зохино.
3. Тендерийн заавал биелүүлэх нөхцөл, тендерийн шаардлага, ХАБЭА-н шаардлагуудад шаардагдах хөрөнгийг гүйцэтгэгч хариуцахаар тусгах шаардлагатай.
4. Ажилбаруудыг иж бүрдлээр нь туршилт тохируулгын хамт 100% хийхээр зардалд тусгана.
5. Тендерт оролцогч нь ажлын эзэлхүүний дагуу төсөв хийхдээ шаардлагатай материалын түүвэр гаргаж нэг бүрчлэн үнэлэн ирүүлнэ. Шаардлагатай материалын орц нормын гүйцэд эсэх нь үнэлгээнд хамаарна.
6. Гагнуурын ажлыг эрх бүхий байгууллагаар шалгуулж баталгаажуулсан байх.
7. Зуухыг засварт оруулахын өмнө захиалагч бүрэн цэвэрлэж, гүйцэтгэгчид хүлээлгэн өгөх бөгөөд их засварын үед гүйцэтгэгч станцын дүрэм, журам шаардлагын дагуу ажлын байрыг цэвэрлэж ажиллах, шаардлага хангахгүй тохиолдолд, тухайн үеийн хяналт шалгалтын протоколоор нарядыг хурааж ажил гүйцэтгээгүйд тооцож, станцын дотоод журмын дагуу ажлын байрны цэвэрлэгээнд ноогдох хариуцлагыг хүлээлгэнэ.
8. Металл шинжилгээ хийх шугам хоолойн өнгөлөгөөг зүлгүүр, зүлгүүрийн машин, хий, элсэн буу зэргээр хийнэ. (Металл хорогдолгүй арга хэрэглэх)
9. Төрөл бүрийн багаж , хэмжих хэрэгслэл, тоног төхөөрөмж, засварын үед хэрэглэх багаж, тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан байх шаардлагатай.
10. Засварын өмнөх туршилтын үнэлгээг гэрээний хавсралт болгон тухайн үед нь оруулна.
11. Техникийн бүх бичиг баримт, формуляруудыг компьютерт хийж хөтлөнө. Компьютерээр хийгээгүй тохиолдолд хүлээж авахгүй .
12. Тендерийн бичиг баримтуудыг бүрдүүлэхдээ тендерт оролцогч байгууллага нь Сангийн сайдын 2012 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн 81 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтад 2019 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн нэмэлт өөрчлөлт орсон АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ТЕНДЕРИЙН ЖИШИГ

БАРИМТ БИЧИГ гэсэн номын дагуу тендерийн бичиг баримт маягтуудыг боловсруулж ирүүлнэ. Үүнээс өөр байдлаар хийж бэлтгэсэн тендерийн бичиг баримтыг хүчингүйд тооцохыг анхааруулж байна.

13. Гүйцэтгэгч талын нийлүүлэх коллекторууд, түүний хийцийн шугам хоолой, цутгамал эд ангиуд нь чанарын хувьд ТУ-14-ЗР-55-2001 эсвэл GB5310-2008 стандарт болон түүнтэй дүйцэхүйц шаардлагыг хангаж байх шаардлагатай. Нийлүүлсэн эд ангиуд нь үйлдвэрийн баталгаажсан чанарын сертификат, паспорттай байх бөгөөд Монгол улсын эрх бүхий итгэмжлэгдсэн хөндлөнгийн лабораторид болон Эрчим хүчний хөгжлийн төвийн лабораторид /нийт 2-оос доошгүй лабораторид/ хэсэгчилсэн сорьц өгч гангийн химийн найрлагын нарийвчилсан шинжилгээ, хатуулгийн шалгалт, металлын бичил бүтцийн шинжилгээ, бат бөхийн агшин зуурын эсэргүүцэл, урсалтын хязгаар, харьцангуй суналт, уртсалтын шалгалтуудыг хийлгэж акт протоколоор баталгаажуулсан байх шаардлагатай. Үүнд гагнуурын утас, электроднууд мөн адил хамаарна.
14. Гүйцэтгэгч тал халах гадаргуу, экран хоолой, таазны уур халаагч, экономайзерийн бүх гагнуурын оёдлыг зөвхөн **аргон гагнуурын** аргаар гагнах бөгөөд 2.1-ээс дээш категоритой, эрх бүхий 4-өөс доошгүй аргон гагнуурчинтай байх шаардлагатай.
15. Нийлүүлэгдэх ган трубаны хувьд ТУ 14-ЗР-55-2001 болон GB/T5310-2017 стандартын ерөнхий шаардлагыг хангасан байх ёстой бөгөөд доорхи тусгай шаардлагуудыг бүрэн хангасан байх ёстой.
16. Нийлүүлэгч нь тендерийн бичиг баримтанд нийлүүлэх трубаны үйлдвэрлэгчийн дараах бичиг баримтуудыг заавал хавсаргана. Үүнд:
 - Нийлүүлэх труба үйлдвэрлэгчийн тамга тэмдэг бүхий баталгаат албан бичиг /захиалагчид хаягласан, нийлүүлэгчтэй холбоотойг гэрчлэх/
 - Тухайн үйлдвэрлэгчийн албан ёсны танилцуулганы эх хувь /үйлдвэрлэлийн процесс, труба үйлдвэрлэдэг технологи, хяналт шалгалтын аргууд, дулаан боловсруулалтын арга төхөөрөмж гэх мэтийг заасан байх/
 - Тухайн үйлдвэр нь албан ёсны үйл ажиллааны вэб хуудастай байх
 - Тендерийн бичиг баримт ирүүлэхдээ тухайн үйлдвэрлэгчийн одоо үйлдвэрлэж байгаа нийлүүлэх трубатай ижил төрлийн трубаны баталгаат сертификатуудыг /гангийн марк, стандарт, химийн найрлага, механик шинж чанарын үзүүлэлтүүд, хатуулаг, микробүтэц гэх мэтийг харуулсан байх ёстой/ хавсаргах
17. Нийлүүлэгч нь труба хоолойнуудыг нийлүүлэхдээ трубаны техникийн үзүүлэлт /гангийн марк, химийн найрлага, гангийн механик шинж чанар, хатуулаг, микробүтэц гэх мэт/ -ийг харуулсан баталгаат сертификатыг эх хувиар нь захиалагч талд хүлээлгэн өгнө.
18. Гүйцэтгэгч тал шугам хоолойн хийцийн угсралтын үеийн гагнуурын оёдлыг гагнахдаа захиалагчаас гаргаж өгсөн технологи зааврыг дагаж мөрдөнө. Гүйцэтгэгч тал өөрийн зардлаар хөндлөнгийн эрх бүхий байгууллагаар гагнуурын оёдлыг гагнасны дараа дотоод үзлэгийг радиографийн шалгалтын аргаар нэг бүрчлэн хийлгэж, тухай бүрт нь захиалагч талд акт протоколыг гаргаж өгөх бөгөөд захиалагч тал хэсэгчилсэн хяналт тавина.
19. Гүйцэтгэгч компани батлагдсан ажлын эзэлхүүнд заасан хийцийн угсралтыг хөндлөнгийн эрх бүхий итгэмжлэгдсэн байгууллагаар металлын шалгалт шинжилгээний ажлыг гүйцэтгүүлнэ. Уг компани нь үл эвдэх сорилт шалгалтын төрөл тус бүрээр эрх бүхий 2-р түвшинээс дээш хүчинтэй сертификаттай техникч, 3-р түвшиний 1-ээс доошгүй инженертэй байх ёстой. Эрх бүхий шалгалтын байгууллагын хүчинтэй итгэмжлэл болон инженер техникчидийн ҮЭС-ийн сертификатуудыг хавсаргасан байна.
20. Гүйцэтгэгч нийлүүлэхээр тендерт тусгагдсан нэр бүхий сэлбэг, материалыг өөрсдөө бүрэн хангаж нийлүүлэх бөгөөд шаардлагатай сертификат, туршилт шалгалтын протоколуудын хамт нийлүүлнэ.

СТ20, 20G маркийн гангаар хийгдсэн үйлдвэрийн уур, усны коллектор, тэдгээрийн хийц эд ангийг хийх шугам хоолойн техникийн шаардлага:

Захиалагч тал нь ТУ-14-ЗР-55-2001 болон GB/T5310-2017 стандартын техникийн шаардлагыг хангасан шугам хоолойг хүлээн авна.

Нийлүүлсэн шугам хоолойн ажиллагааны баталгаат хугацаа нь 3 жилээс доошгүй байх ёстой.

1. Гангийн химийн найрлагын хувьд: %

| Гангийн марк | Нүүрстөрөгч | Цахиур | Марганц | Хром | Зэс | Хүхэр | Фосфор |
|-----------------|-------------|-----------|-----------|-------|--------|---------|---------|
| СТ20 | 0.18-0.24 | 0.17-0.37 | 0.35-0.65 | < 0.4 | ≤ 0.15 | ≤ 0.015 | ≤ 0.015 |
| 20G | 0.17 – 0.24 | 0.17-0.37 | 0.35-0.65 | - | - | ≤ 0.015 | ≤ 0.015 |

2. Дулаан боловсруулалт нь дараах горимоор хийгдсэн байх ёстой.

| Гангийн марк | Хэвшрүүлэлт хийх горим | Амраалт хийх горим |
|--------------|------------------------|--|
| СТ20 | 920-950°C | Хэвшүүлэлтийн дараах өндөр температурын амраалт хийх |
| 20G | 900-930°C | Хэвшүүлэлтийн дараах өндөр температурын амраалт хийх |

3. Гангийн механик шинж чанарын үзүүлэлт нь /тасалгааны температурт/:

| Гангийн марк | Хугацааны эсэргүүцэл, σ_{B_s} Н/мм ² , (кгс/мм ²) | Урсгалтын хязгаар, $\sigma_2^{0.2}$ Н/мм ² , (кгс/мм ²) | Харьцангуй суналт, ϵ, δ_5 % | Харьцангуй уртсалт, $\Psi, \%$ | Цохилтын зуурамтгай чанар, КСУ, Дж/см ² (кгсм/см ²) |
|-----------------|---|--|---|--------------------------------|--|
| СТ20 | 412-549 (42-56) | 216 (22) | 24 | 45 | 49 (5) |
| 20G | 410-550 | 245 | 24 | - | 35 |

4. Гадаргуугийн чанар

Хоолойн гадаад болон дотоод гадаргууд цууралт ан цав, давхар хана, жигд биш байдал, урагдалт, язралт, гүнзгий зурагдалт, хуниралт атиралт зэрэг гэм согогууд байхыг хориглоно.

5. Макро болон микро бүтэц

5.1. Металлын макро бүтэц нь ан цав цууралт, үе давхраа, жигд биш байдал, өөр төрлийн металл болон металл биш шааргын хольцтой байхыг хориглоно.

44.2. Ажил бүрэн дууссан тухай мэдэгдлийг үндэслэн суутгасан үнийн дүнгийн 50 хувийг гүйцэтгэгчид төлөх бөгөөд үлдсэн хэсгийг чанарын баталгаат хугацаа дууссаны дараа тэр хугацаанд гарсан бүх зөрчил, гологдлыг гүйцэтгэгч арилгасан тухай төслийн менежерийн мэдэгдлийг үндэслэн төлнө.

44.3. Ажлыг бүхэлд нь дуусгамагц гүйцэтгэгч захиалагчид банкны батлан даалт гаргаж өгснөөр уг батлан даалтад заасан дүнтэй тэнцүү хэмжээний төлбөрийг барьцаа хөрөнгөөс урьдчилж авч болно.

45. Алданги

45.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги¹⁸ төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно.

¹⁷ Барьцаа хөрөнгийн дүн 5 орчим хувь байх бөгөөд ямар ч тохиолдолд 10 хувиас хэтрэх ёсгүй.

¹⁸ Алдангийг ихэвчлэн хоногт 0,05-0,10 хувиар тогтоох бөгөөд нийт дүн нь гэрээний үнийн 5-10%-иас хэтрэх ёсгүй.

Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.

45.2. Хэрэв алданги төлснөөс хойш ажил дуусгахаар төлөвлөсөн хугацааг сунгасан бол төслийн менежер гүйцэтгэгчийн илүү төлсөн алдангийг дараагийн төлбөрийн мэдэгдэлд тооцох замаар залруулна. Илүү төлсөн алдангид алдангийн төлбөр хийсэн өдрөөс алдангийг буцаан төлөгдсөн өдөр хүртэл хугацааны хүүг ТООЗ-ны 40.1-д заасан хувиар тооцож гүйцэтгэгчид төлнө.

46. Урамшуулал

46.1. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс өмнө дууссан хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр гүйцэтгэгчид урамшуулал¹⁹ олгоно. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр болоогүй боловч гүйцэтгэгч ажлыг бүрэн дуусгасан бол төслийн менежер энэ тухай мэдэгдэл гаргана.

47. Урьдчилгаа төлбөр

47.1. ²⁰Захиалагч гэрээний тусгай нөхцөлд заасан дүнтэй урьдчилгаа төлбөрийг уг өгөгдөлд заасан хугацаанд гүйцэтгэгчид төлнө. Урьдчилгаа төлбөрийн дүнтэй тэнцүү, ижил валютаар илэрхийлэгдсэн банкны батлан даалт буюу үл маргах нөхцөлтэйгээр банкнаас гаргасан урьдчилгаа төлбөрийн баталгааг үндэслэн энэхүү төлбөрийг хийнэ. Гэхдээ энэ батлан даалтын дүн нь гүйцэтгэгчийн эргэж төлөгдсөн урьдчилгаа төлбөрийн хэмжээгээр буурч байна. Урьдчилгаа төлбөрт хүү ногдуулахгүй.

47.2. Гүйцэтгэгч урьдчилгаа төлбөрийг зөвхөн гэрээг гүйцэтгэхэд шаардагдах тоног төхөөрөмж, байгууламж, материал болон ажил эхлүүлэхтэй холбогдсон зардалд зарцуулна. Гүйцэтгэгч урьдчилгаа төлбөрийг энэ зорилгод ашигласныг нотлохын тулд нэхэмжлэх болон бусад баримтын хувийг төслийн менежерт ирүүлнэ.

47.3. Урьдчилгаа төлбөр нь хийгдсэн үе шатны ажлын дагуу гүйцэтгэгчид төлөх төлбөрийн хэмжээнээс холбогдох дүнг суутгах замаар эргэж төлөгдөнө. Хийгдсэн ажлын үнэ, өөрчлөлт, үнийн тохируулга, нөхөн төлбөр, урамшуулал болон алдангийн дүнг тооцохдоо урьдчилгаа төлбөр, эсхүл түүний эргэж төлөгдсөн байдлыг харгалзахгүй.

48. Баталгаа

48.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэлд заасан хугацаанаас хоцроолгүй гүйцэтгэлийн баталгааг захиалагчийн хүлээн зөвшөөрөх дүн, маягт, банкаар гаргуулан, гэрээний үнийг төлөх валютаар илэрхийлэн захиалагчид ирүүлнэ. Гүйцэтгэлийн баталгааны хүчинтэй байх хугацаа дуусах өдөр нь ажил дууссан тухай мэдэгдэл гарсан өдрөөс хойш 28 дахь өдөр байна.

49. Ажил-өдөр

49.1. Зөвхөн төслийн менежерийн урьдчилан бичгээр гаргасан зааварчилгааны дагуу бага хэмжээний нэмэлт ажлын төлбөрийг тендерт дурдсан ажил-өдрийн нэгж үнийг ашиглаж тооцно.

49.2. Гүйцэтгэгч ажил-өдрөөр тооцогдон төлөгдөх бүх ажлын талаар төслийн менежерийн баталсан маягтын дагуу тэмдэглэл

¹⁹ Ажлыг төлөвлөсөн хугацаанаас өмнө дуусгах нь захиалагчид ашигтай бол энэ заалтыг үлдээх ба бусад нөхцөлд буюу ихэнх тохиолдолд хасна. Урамшууллын хэмжээ нь ихэвчлэн алдангийн хэмжээтэй ижил байна.

²⁰ Хэрэв урьдчилгаа төлбөр байхгүй, эсхүл урьдчилгаа төлбөр байгаа нөхцөлд урьдчилгаа төлбөр хийхийн тулд урьдчилгаа төлбөрийн банкны батлан даалт авах шаардлагагүй гэж үзвэл захиалагч эхний 2 өгүүлбэрийг хасаж болно.

хөтөлнө. Бөглөсөн маягтыг төслийн менежер ажил гүйцэтгэснээс хойш 2 хоногийн дотор шалгаж батална.

49.3. Батлагдсан ажил-өдрийн маягтыг үндэслэн төлбөрийг гүйцэтгэгчид төлнө.

50. Засварын зардал

50.1. Ажил эхэлсэн өдрөөс чанарын баталгаат хугацаа дуусах хүртэл хугацаанд гүйцэтгэгчийн үйл ажиллагаанаас, эсхүл дутуу орхисноос үүдэн гарсан гэрээний ажилтай холбоотой материал болон ажилд үүссэн алдагдал, эвдрэл гэмтлийг гүйцэтгэгч өөрийн зардлаар засварлана.

Д. ГЭРЭЭГ ДУУСГАХ

51. Ажил дуусгах

51.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.

52. Хүлээж авах

52.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш долоо хоногийн дотор захиалагч ажлын талбай болон ажлыг хүлээж авна.

53. Эцсийн тооцоо

53.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ. Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 28 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно. Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаар тайлбарыг 28 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.

54. Ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлага

54.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.

54.2. Хэрэв гүйцэтгэгч 55.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг суутгана.

55. Гэрээг цуцлах

55.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.

55.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:

(а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер

батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;

- (б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;
- (в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад шалтгаанаар татан буугдсан;
- (г) захиалагч төслийн менежерийн гаргасан төлбөрийн мэдэгдлийн дагуу төлөх төлбөрийг уг мэдэгдлийг гаргасан өдрөөс хойш 60 хоногийн дотор төлөөгүй;
- (д) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;
- (е) гүйцэтгэгч захиалагчийн шаардсан баталгааг хангаагүй;
- (ё) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.

55.3. Хэрэв гэрээний аль нэг тал дээрх 56.2-т зааснаас өөр үндэслэлээр гэрээг ноцтой зөрчсөн тухай мэдэгдлийг төслийн менежерт өгсөн бол төслийн менежер тухайн үндэслэл нь ноцтой зөрчил мөн эсэхийг шийдвэрлэнэ.

55.4. Захиалагч шаардлагатай тохиолдолд дээр дурдсаныг үл харгалзан гэрээг цуцлах эрхтэй.²¹

55.5. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.

56. Гэрээг цуцалсан үед хийх төлбөр

56.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл төлөгдсөн урьдчилгаа төлбөр болон дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй. Хэрэв захиалагчид төлөх төлбөрийн нийт дүн гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс хэтэрвэл, хэтэрсэн дүн нь гүйцэтгэгчээс захиалагчид төлөх ёстой өр болно.

56.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл гаргасан

²¹ Захиалагч гэрээг цуцлах шийдвэрийг холбогдох дээд шатны байгууллагын зөвшөөрөлтэйгээр зөвхөн зайлшгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд гаргана.

өдөр хүртэл төлөгдсөн урьдчилгаа төлбөрийг эдгээр зардлаас хасна.

57. Өмч

57.1. Гүйцэтгэгчийн буруугаас шалтгаалж гэрээ цуцлагдсан бол ажлын талбай дээрх захиалагчаас үнийг нь төлсөн бүх материал, байгууламж, тоног төхөөрөмж, туслах ажил болон ажлыг захиалагчийн өмч гэж үзнэ.

58. Гүйцэтгэлээс чөлөөлөх

58.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсооно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ

ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

Гэрээний тусгай нөхцөлийг бөглөх санамж

Захиалагч тендерийн баримт бичгийг тараахаас өмнө гэрээний тусгай нөхцөлийг бүрэн тодорхойлж гаргасан байна. Захиалагч холбогдох хуваарь, тайланг гэрээний тусгай нөхцөлд хавсаргана.

Дор дурдсан баримт бичиг нь гэрээний хэсэг болно:

- 55.0** Засварын ажлын үе шатны ажлын хуваарь
 - 1.1 Захиалагч: **ДЦС-3 ТӨХК Засвар хяналтын алба**
 - 1.1 Төслийн менежер: **Ш.Мөнхцог, ЗХА-ны зуухны засвар хяналтын инженер**
 - 1.1 Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар нь **“ЗАСВАР-02, 2020”**
 - 1.1 Ажил нь **“БКЗ-75-39ФБ маркийн зуух №6-ийн их засварт шаардлагатай материал нийлүүлж, их засварын ажил гүйцэтгэх”**
 - 1.1 Ажил эхлэх өдөр **2020 оны 06 дугаар сарын 01-ний өдөр**
 - 1.1 Ажлын талбай нь **ДЦС-3 ТӨХК-ий Дунд даралтын зуухан цех** болно.
- 3.0** Гэрээний баримт бичгүүд нь **Монгол** хэл дээр байна.
- 3.0** Гэрээнд Монгол Улсын хуулийг хэрэглэнэ.
- 17** Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр **2020 оны 09 дүгээр сарын 01-ний өдөр**²²
- 21.0** Ажлын талбайг ашиглуулж эхлэх өдөр **2020 оны 06 дугаар сарын 01-ний өдөр**²³
- 25.0** Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш **14** хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.
- 25.0** Ажлын хөтөлбөрийг **7** хоног тутам тодотгоно.
- 32.0** Чанарын баталгаат хугацаа **365**²⁴ хоног байх бөгөөд баталгаат хугацаанд гарсан гэмтлийг цаг тухайд шуурхай гүйцэтгэх ба гэмтэл саатал гараагүй тохиолдолд 6 сарын дараа гэрээний үнийн дүнгийн 5%-ийг олгоно.
- 40.0** Төлбөр хийх хугацаа нь төлбөрийн мэдэгдэл гаргасан өдрөөс хойш **30**²⁵ хоног байна.
- 46.0** Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний гүйцэтгээгүй ажил үүргийн үнийн дүнгийн **0,3 хувь** байна.²⁶
- 46.0** Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн **30 хувь** байна.

22 Ажлыг хэсэгчлэн дуусгахаар төлөвлөсөн бол эдгээр хугацааг жагсаана.
23 Ажлын талбайг хэсэгчлэн эзэмшүүлэх бол эдгээр хугацааг жагсаана.
24 Энэ хугацааг ихэвчлэн Иргэний хуульд нийцүүлж авна.
25 Энэ хугацаа 3 сараас илүүгүй байна.
26 Ажлыг хэсэг хэсгээр дуусгах болон хэсэг бүрт алданги хэрэглэх бол энд тусгана.

- 49.0** Гүйцэтгэлийн баталгаа нь гэрээний үнийн **5 хувь**–тай тэнцүү дүнтэй байна.
- Гэрээний үүргийг бүрэн болон хэсэгчилэн биелүүлээгүй тохиолдолд гүйцэтгэлийн баталгаа олгохгүй. Энэ нь алдангиас чөлөөлөх үндэслэл болохгүй.
- Гүйцэтгэлийн баталгаа нь тендерийн баримт бичгийн 7дугаар бүлэгт заасан маягтын дагуу байна.
- 55.0** Гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан актыг **10 хоногийн** дотор гаргаж өгнө. Засварын ажлын гүйцэтгэл, акт, формулярыг ажил дууссанаас хойш **14** хоногийн дотор гаргаж өгнө.
- 55.0** Дээрх материалыг хугацаанд нь гаргаж өгөөгүй тохиолдолд суутгах төлбөрийн хэмжээ гэрээний үнийн дүнгийн **0,05 хувь** байна.
-

ДОЛДУГААР БҮЛЭГ

ГЭРЭЭНИЙ МАЯГТ²⁷

Гэрээний жишиг маягтыг бөглөх санамж

Алдаа залруулах (тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны 31 дүгээр зүйл), үнэлгээний үед үнийн тохируулга хийх (тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны 17.9; гэрээний ерөнхий нөхцөлийн 44 дүгээр зүйл), хувилбарт тендер сонгох (тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны 16.1), материаллаг бус зөрүүг (тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны 30 дугаар зүйл) хүлээн зөвшөөрсний улмаас тендерт хийсэн аливаа залруулга, нэмэлт өөрчлөлт болон голлох мэргэжилтэн, туслан гүйцэтгэгч, хуваарийн өөрчлөлт гэх мэт харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан өөрчлөлтүүд нь гэрээний салшгүй хэсэг болно.

²⁷ Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

**ДОЛДУГААР БҮЛЭГ
ГЭРЭЭНИЙ МАЯГТ**

БАТЛАВ
“ДЦС-3” ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ
...../...../

БАТЛАВ
..... ХХК-ИЙН
..... ЗАХИРАЛ
...../...../

**БКЗ-75-39ФБ МАРКИЙН ЗУУХ №6-ИЙН ИХ ЗАСВАРТ ШААРДЛАГАТАЙ
МАТЕРИАЛ НИЙЛҮҮЛЖ, ИХ ЗАСВАРЫН
АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ**

2020 оны-р сарын -ны өдөр

№.

Улаанбаатар хот

Нэг талаас “ДЦС-3” ТӨХК-г төлөөлж (цаашид “Захиалагч” гэх), нөгөө талаас ХХК-ийг төлөөлж (цаашид “Гүйцэтгэгч” гэх) нар Монгол Улсын Иргэний хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, “ДЦС-3” ТӨХК-ийн Үнэлгээний хорооны хурлын 2020 оны-р сарын-ний өдрийн тоот тэмдэглэл, Үнэлгээний хорооны 2020 оны-р сарын-ны өдрийн тоот зөвлөмжийг үндэслэн харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

ГЭРЭЭНИЙ ЗОРИЛГО

“БКЗ-75-39ФБ маркийн зуух №6-ийн их засварт шаардлагатай материал нийлүүлж, их засварын ажил гүйцэтгэх” ажлыг тендерийн баримт бичигт заасан шалгаруулалт, шаардлагад нийцүүлэн графикт хугацаанд чанартай, технологийн дагуу хийж гүйцэтгэн хүлээлгэж өгөх, захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтоох, төлбөр тооцоог гэрээнд заасан хугацаанд хийж гүйцэтгэхэд гэрээний зорилго оршино.

НЭГ. ҮНДСЭН ОЙЛГОЛТ БА ТАЙЛБАР

- 1.1. Энэхүү гэрээнд тусгагдсан нэр томъёо, үндсэн ойлголт нь доорх утгыг агуулна.
- Гэрээ–Гүйцэтгэгч ба захиалагч талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулсан баримт бичиг
 - Ажлын эзэлхүүн–тендерийн баримт бичигт тусгагдсан тухайн их засварын үед хийх ажил, үйлчилгээний жагсаалт, тэдгээрийн тоо хэмжээ
 - Материал сэлбэг–тендерийн баримт бичгийн дагуу тухайн их засвараар хийх ажил, үйлчилгээг гүйцэтгэхэд шаардлагатай сэлбэг, материалын жагсаалт, тоо хэмжээ
 - Захиалагчийн хяналт– захиалагч талаас ажил гүйцэтгэх явцад гүйцэтгэгчийн ажилд хяналт тавихаар томилогдсон эрх бүхий албан тушаалтан, гүйцэтгэх ажлын төрлөөс хамаарч нэг буюу хэд хэд байж болно
 - Техникийн шаардлага–тендерийн баримт бичигт тусгагдсан, их засварын үед нийлүүлэх сэлбэг, материалын үйлдвэрлэсэн стандарт шаардлага, засварын дараа үндсэн ба туслах тоноглолд тавигдах техник ашиглалтын дүрэмд нийцсэн техникийн нормт үзүүлэлтүүд

ХОЁР. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 2.1. Гүйцэтгэгч нь “БКЗ-75-39ФБ маркийн зуух №6-ийн их засварт шаардлагатай материал нийлүүлж, их засварын ажил гүйцэтгэх” ажлыг тоноглолыг их засварт хүлээн авсан тухай хоёр тал тэмдэглэл үйлдэж, 2020 оны-р сарын-ны өдрөөс гэрээт ажлыг эхэлсэнд тооцно.
- 2.2. Ажлын талбай ашиглаж эхэлснээс хойш өдрөөс хойш хуанлийн 90 хоногт буюу 2020. Оны 08-р сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд батлагдсан графикайн дагуу хийж гүйцэтгэнэ.

- 2.3. Гүйцэтгэгч нь тендерийн баримт бичигт дурьдсан сэлбэг материалыг засварын ажлын явц, графикт хугацаанд нөлөөлөхгүй бүрэн нийлүүлнэ.
- 2.4. Засварын явцад гарсан хүндрэл, ажлын эзэлхүүнд тусгагдаагүй нэмэлт ажлыг хоёр талын эрх бүхий албан тушаалтнууд шийдвэр гаргаж тендерийн баримт бичигт заасны дагуу гүйцэтгэгч тендерийн үнэд багтаан хийж гүйцэтгэнэ.
- 2.5. Гүйцэтгэсэн ажлыг хүлээлгэн өгөх, хүлээн авахдаа “Тоноглолыг засвараас хүлээн авах” журмын дагуу гүйцэтгэгч захиалагчийн эрх бүхий албан тушаалтнууд хүлээлцэж баталгаажуулна.
- 2.6. Гүйцэтгэгч хийц, эд анги үйлдвэрлэх тохиолдолд хоёр талын баталсан үндсэн ажлын графикт нөлөөлөхгүйгээр хийж угсралтанд бэлэн болгоно.

ГУРАВ. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 3.1 **“БКЗ-75-39ФБ маркийн зуух №6-ийн их засварт шаардлагатай материал нийлүүлж, их засварын ажил гүйцэтгэх”** ажлыг тендерийн баримт бичигт заагдсан ажлын эзэлхүүний дагуу, нөхцөл, шаардлагыг хангасан материалаар тендерт шалгарсан үнэд багтаан, батлагдсан графикт хугацаанд чанартай хийж гүйцэтгэх.
- 3.2 Гүйцэтгэгч өөрийн тоног төхөөрөмж, багажны төрлийн материал, агуулах сав зэргийг өөрсдөө бүрэн хариуцаж, ажлын байранд бэлэн байлгах бөгөөд эдгээрийг оруулж, гаргах байрлуулах зөвшөөрлийг захиалагч талаас авна.
- 3.3 Гүйцэтгэгч нь засварын ажлын хугацаанд тоноглолын бүрэн бүтэн байдлыг бүрэн хариуцна.
- 3.4 Гүйцэтгэгч нь захиалагч талын дотоод журам болон бусад дүрэм зааврыг мөрдөж ажиллах.
- 3.5 Шаардлагатай эд ангийн зорлого, металл боловсруулалтын ажил, бүх төрлийн хийг гүйцэтгэгч өөрөө хангах бөгөөд захиалагчийн механик цехэд гүйцэтгүүлбэл тусгай маягтаар захиалгаа өгч төлбөрийг хоорондын тооцоогоор төлнө.
- 3.6 Гүйцэтгэгч нь гэрээт ажлын хугацаанд өөрийн ажилтнуудын нийгмийн болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлыг бүрэн хариуцах бөгөөд ГАУСД, ТАД, ААД-г мөрдөж ажиллах бөгөөд ХАБЭА-н орон тооны ажилтанг томилон ажиллуулах.
- 3.7 Станцын /захиалагч/ журам, дүрмийг зөрчсөн /согтууруулах ундаа хэрэглэсэн, танхайрсан, эд хөрөнгийг хулгайлсан гэх мэт/ тохиолдолд уг ажилтанг станцын нутаг дэвсгэрт дахин нэвтрүүлэхгүй байх.
- 3.8 Гүйцэтгэгчийн буруугаас тоног төхөөрөмж эвдэж гэмтээвэл актын дагуу төлбөрийг төлж захиалагчийг хохиролгүй болгох.
- 3.9 Долоо хоног бүр засварын ажлын гүйцэтгэлийг бичгээр гаргаж захиалагч талд танилцуулж, шийдвэрлүүлэх асуудлыг засварын шуурхай зөвлөлгөөнд оруулж эрх бүхий албан тушаалтныг байлцуулан шийдвэрлүүлж уг асуудлаар тэмдэглэл үйлдэж баталгаажуулна.
- 3.10 Гүйцэтгэгч нь тендерийн нөхцлийн дагуу техникийн баримт бичгийг бүрдүүлнэ. Үүнд:
- Нэхэмжлэх
 - Ажлыг хүлээлгэн өгсөн, хүлээн авсан акт
 - Төсвийн гүйцэтгэл
 - Засварын сэлбэг материалын зарцуулалтын тайлан
- 3.11 Ерөнхий нарыадад заагдсан аюулгүйн арга хэмжээнүүд бүрэн авагдаж нарыа нээгдсэнээс хойш засвар дуусаж 72 цаг явуулж илэрсэн гэмтэл устгах ажлын нарыадууд хаагдах хүртэл хүний амь нас хохирсон осол, бүлэг осол, хурц хордлого, галын зөрчил гаргавал гарсан хохирлыг тухайн ажил гүйцэтгэгч тал шууд хариуцна.
- 3.12 Сэлбэг материал зөөх, хог хаягдал ачих, асгах болон бусад ажилд шаардлагатай тээврийн хэрэгсэлээ өөрсдөө бүрэн хариуцна.
- 3.13 Гэрээгээр нийлүүлэгдэх материал болон засварын ажилд хэрэглэгдэх материал сэлбэг, техник хэрэгслийг харуулын постоор бүртгүүлж оруулж гаргана.
- 3.14 Гүйцэтгэгч нь захиалагчийн хяналтын дор тоноглолын засварын технологийг мөрдөж ажиллах.
- 3.15 Гүйцэтгэгч нь их засварын үед солигдсон хуучин хаалт, арматур, шугам хоолой, сэлбэг материалыг агуулахад тушааж баримт бүрдүүлэх.
- 3.16 Гүйцэтгэгч нь кранчинг ажлын бус цагаар ажиллуулах үед ажлын байрны зааварчилгаа, аюулгүй ажиллагааг нь ханган ажиллуулж, илүү цагийн хөлсийг холбогдох хууль тогтоомж, станцын хамтын гэрээний дагуу бодож олгоно.
- 3.17 Гүйцэтгэгч нь гэрээний дагуу ажил гүйцэтгэх ажилтнуудын нэрс, албан тушаал, ажлын зэрэг, нарыадын тусгай үүрэг гүйцэтгэгчийг тодорхой бичих бөгөөд гэрээний хавсралтанд заагдсан нэрсийн жагсаалтанд байхгүй ажилтанг авч ажиллуулахгүй байх.

- 3.18 Гүйцэтгэгч нь гэрээний дагуу ажил гүйцэтгэхдээ ажлын туршлагатай /ерөнхий инженер ба ажил удирдагч, ХАБЭА-н ажилтан, засварын мастер, талбайн удирдагч/ мэргэжилтэнг томилон ажиллуулах.
- 3.19 ЭХ-ний үйлдвэрүүдэд засварын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүд гэрээ байгуулахдаа ажлын аюулгүй байдлыг хариуцагч, тухайн засвар дээр ажиллах хүмүүс, нарядын тусгай үүрэг хүлээгчдийг томилсон тушаал хавсаргах бөгөөд оосорлогч дохиочин нар нь ээлжит шалгалт өгч эрх авсан байна.
- 3.20 Тухайн ажлыг гүйцэтгүүлэхэд зөвхөн тендерийн баримт бичигт дурьдсан туслан гүйцэтгэгчийг түншлэлийн гэрээний үндсэн дээр авч ажиллуулах бөгөөд туслан гүйцэтгэгчийн хийж гүйцэтгэх ажлын эзэлхүүн төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах хуулийн дагуу нийт ажлын 10 хувиас хэтэрч болохгүй.
- 3.21 Засварын гэрээ батлагдсаны дараа гэрээгээр ажиллах бүх ажилтнуудад урьдчилсан зааварчилгаа өгөгдсөний дараа үйлдвэрт нэвтрэх үнэмлэх авах.
- 3.22 Гүйцэтгэгч нь гэрээ батлагдсан өдрөөс эхэлж засварын ажил дуусаж тоноглолыг 72 цаг явуулж, гарсан гэмтлийг устгаж бүрэн хэмжээгээр нь захиалагч талд хүлээлгэн өгөх хүртэл ХАБЭА-г бүрэн хариуцаж ажиллах үүрэгтэй.
- 3.23 ХАБЭА-н тухай хуулийн дагуу эрүүл мэндийн үзлэгт орсон, уг хуулийн 17.2.3-д заасан ажлын байрны зохих сургалтанд хамрагдаж ТАД болон ААД-н ээлжит шалгалт өгч тэнцсэн ажилтанг ажиллуулах.
- 3.24 Ажил гүйцэтгэхэд шаардлагатай сэлбэг, материалыг станцын хашаанд оруулах үед тоо хэмжээг харуулд бүртгүүлэн, эрх бүхий албан тушаалтануудын хяналтаар нэвтрүүлнэ. Хэрэглэсэн материал сэлбэгийн зарцуулалтыг захиалагчид тайлагнах, төсөвт тусгагдсан үлдэгдэл материалыг ажил гүйцэтгэж дууссаны дараа захиалагчид шилжүүлэх үүрэгтэй.
- 3.25 Гүйцэтгэгч нь гэрээт ажлын баталгаат хугацаанд гэрээний нийт үнийн дүнгийн 5%-тай тэнцэх төлбөрийг гүйцэтгэгчийн дансанд барьцаа болгон үлдээнэ.
- 3.26 Баталгаат хугацаанд тухайн тоноглолд гэмтэл саатал гарвал захиалагчийн мэдэгдэл, шаардлагын дагуу цаг хугацаанд нь хийж гүйцэтгэн хүлээлгэн өгөх үүрэгтэй бөгөөд шаардлага биелүүлээгүй тохиолдолд захиалагч тал уг гэмтлийг арилгаж, барьцаа төлбөрөөс суутган тооцно.
- 3.27 Гүйцэтгэгч нь гэрээгээр засварын ажил гүйцэтгэх ажилчиддаа гэнэтийн ослын даатгал заавал хийлгэсэн байвал зохино.
- 3.28 Гүйцэтгэгч нь гэрээгээр гүйцэтгэж байгаа ажлын материалын сонголт болон хийц хийж байх үеийн явцад захиалагчийн төлөөллийг хяналт тавих боломжоор хангах ба түүнтэй холбогдон гарах зардлыг бүрэн хариуцна

ДӨРӨВ. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 4.1. Захиалагч нь тухайн ажлын явцад ерөнхий нөхцөл /гэрэлтүүлэг, агааржуулалт, цэвэр ус, ахуйн байр/-р хангаж, цахилгаан эрчим хүч болон гүүрэн кранаар хангах үүрэгтэй.
- 4.2. Захиалагч нь засварын явцад засварын технологи, гүйцэтгэлд хяналт тавих, уг тоноглолыг хариуцсан засварын инженерийг томилон ажиллуулах.
- 4.3. Захиалагчийн буруугаас тоноглол гэмтсэн тохиолдолд уг тоноглолыг сэргээн засварлахыг гүйцэтгэгчээс шаардах эрхгүй.
- 4.4. Захиалагч нь тендерийн баримт бичиг, нөхцөл шаардлагын дагуу ажлыг гүйцэтгүүлэхээр гүйцэтгэгчид шаардлага тавих эрхтэй.
- 4.5. Захиалагч нь гүйцэтгэгч талын хүсэлтээр дотоод үйл ажиллагаанд нөлөөлөхгүй тохиолдолд металлын зорлого боловсруулалтын ажлыг гүйцэтгүүлж зохих төлбөр тооцоог нэхэмжилнэ.
- 4.6. Захиалагч тал уг тоноглолын үндсэн зураг схемийг гүйцэтгэгч талд ашиглуулах үүрэгтэй. /архив/
- 4.7. Захиалагч ажлын гүйцэтгэлийг үндэслэн гэрээнд заасны дагуу санхүүжилт хийнэ.
- 4.8. Гэрээг дүгнэхдээ ХАБЭА–н ажилтнаас санал дүгнэлтийг авна.
- 4.9. Ажил гүйцэтгэгчийн тавьсан шаардлагын дагуу чанар муутай буюу шаардлага хангахгүй сэлбэг материалыг сольж өгөх, ажлын чанар, үр дүнд муугаар нөлөөлөх бусад нөхцөл байдлыг арилгах талаар өөрөөс шалтгаалах бүхий л арга хэмжээг авах үүрэгтэй.
- 4.10. Захиалагч нь засварт хэрэглэгдэх сэлбэг материалын чанар, зарцуулалтанд хөндлөнгийн хяналт тавьж үлдэгдэл материалыг буцаан гаргах зөвшөөрөл олгоно.
- 4.11. Нийлүүлэгдэх материал, сэлбэг, эд ангийн нэр төрөл, тоо хэмжээг гаргаж, гэрээнд хавсралт №1-р оруулна.
- 4.12. Захиалагч тал нь шаардлагатай материал, сэлбэг, эд ангийн техникийн шаардлагыг үйлдвэрт захиалга хийх хэмжээнд хавсралт №2-р гаргаж өгөх бөгөөд захиалгын буруугаас үүдэх хугацааны болон материалын хохирлыг бүрэн хариуцна.

ТАВ. ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

5.1. Гүйцэтгэгчийн буруугаас ажил гүйцэтгэх гэрээнд заасан хугацааг хожимдуулснаас тоноглолын засварын хугацааг сунгах, хэрэглэгчдийг эрчим хүчээр тасалдуулах, хязгаарлахад хүрсэн бол үүнээс үүдэн гарсан хохирлыг гүйцэтгэгч нь захиалагчийн өмнө бүрэн хариуцна.

5.2. Гүйцэтгэгч нь их засварын ажлыг батлагдсан графикт хугацаанаас хэтрүүлбэл талууд харилцан тохиролцож гэрээний хугацааг сунгаж гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулснаас бусад тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй ажил үүргийн үнийн дүнгийн 0,3%-тай тэнцэх алдангийг захиалагчид төлөх ба нийт алдангийн дүн нь гэрээний үнийн дүнгийн 10%-иас хэтрэхгүй байна. Алданги тооцож эхэлсэн тухайгаа гүйцэтгэгч талд захиалагч нь мэдэгдэнэ.

5.3. Гэрээний үүргийг бүрэн болон хэсэгчлэн биелүүлээгүй тохиолдолд гүйцэтгэлийн баталгаа олгохгүй. Энэ нь алдангиас чөлөөлөгдөх үндэслэл болохгүй.

5.4. Захиалагч нь хөдөлмөрийн аюулгүй байдлыг жигд хангаж хэвшүүлэх зорилгоор байгууллагын хэмжээнд мөрдөж байгаа журмын дагуу зөрчил бүрийг бүртгэн авч 30,0 мянган төгрөг, шууд хариуцан ажилладаг ИТА-д 15,0 мянган төгрөгийн торгууль оногдуулна

5.5. ХАБЭА-н тухай хууль, болон компанийн хөдөлмөрийн дотоод журмыг мөрдөж ажиллах ба хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах талаар муу ажилласан, осол болон осолд дөхсөн тохиолдол, галын ноцтой зөрчил, нарядын системийг удаа дараа зөрчсөн ажилтнуудыг “ДЦС-3” ТӨХК-д нэвтрэх үнэмлэхийг хураан авч гэрээ цуцлах хүртэл арга хэмжээ авах бөгөөд захиалагч талд учирсан хохирлыг гүйцэтгэгч тал бүрэн хариуцна.

5.6. ХАБЭА-н шаардлага хангаагүйн улмаас гүйцэтгэгч талд торгууль оногдуулсан тохиолдолд гэрээт ажлын гүйцэтгэлээс тооцож суутгана.

5.7. Уг тоноглолын их засварын баталгаат хугацаа 12 сар байх бөгөөд баталгаат хугацаанд гарсан гэмтлийг цаг тухайд нь шуурхай гүйцэтгэх ба гэмтэл саатал гараагүй тохиолдолд 6 сарын дараа засварын баталгаат хугацааны барьцаа 5%-ийг гүйцэтгэгч талд олгож болно.

5.8. **“БКЗ-75-39ФБ маркийн зуух №6-ийн их засварт шаардлагатай материал нийлүүлж, их засварын ажил гүйцэтгэх”** ажлын гэрээгээр шинээр нийлүүлэгдсэн булан хоолой, шугам хоолой, шилжвэр, тройник гэх мэт металл эд ангиудын чанарын баталгаат хугацаа нь 3 жил байна. Энэ хугацаанд нийлүүлсэн материалаас хамаарч гарсан хохирлыг гүйцэтгэгч бүрэн барагдуулна.

5.9. **“БКЗ-75-39ФБ маркийн зуух №6-ийн их засварт шаардлагатай материал нийлүүлж, их засварын ажил гүйцэтгэх”** ажлын гэрээгээр нийлүүлж байгаа булан хоолой, шулуун хоолой, шилжвэр, тройник, гагнуурын электродны техникийн үзүүлэлтүүд нь тендерийн бичиг баримтанд заагдсаны дагуу байх ёстой бөгөөд гүйцэтгэгч нь үүнийг Монгол улсын эрх бүхий лабораторит шалгуулан баталгаажуулж акт протоколийг, үйлдвэрийн чанарын сертификатын хамт хавсаргаж ирүүлнэ. Угсралтын үеийн гагнуурын оёдлын болон металлын чанарын шалгалтыг гүйцэтгэгч эрх бүхий мэргэжилтэнээр гүйцэтгүүлнэ

5.10. Захиалагч тал нь гүйцэтгэгчийн нийлүүлсэн металл эд анги, материалд болон угсралтын үеийн гагнуурын технологи ажиллагаанд хэсэгчилсэн болон бүрэн шалгалт шинжилгээг хийж баталгаажуулна.

5.11. Мэргэжлийн бус, сургалтанд хамрагдаагүй гэрээт компанийн бус хүмүүсийг олноор туслах ажилчнаар үйлдвэрт оруулахыг хориглоно.

ЗУРГАА. ГЭРЭЭ ЦУЦЛАХ

6.1. Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр бараа нийлүүлэх хугацаа хожимдуулсан, цаашид засварын ажлыг үргэлжлүүлэх боломжгүй болсон тохиолдолд захиалагчийн санаачилгаар гэрээг цуцалж гүйцэтгэлийн баталгааг өөрийн дансанд шилжүүлэн авна.

6.2. Гэрээг хэрэгжүүлэх явцад мэргэжлийн /үйл ажиллагаанд/ ноцтой алдаа гаргасан түүнийг нуун дарагдуулах оролдлого хийсэн тохиолдолд гэрээг цуцлах.

6.3. Станцын /захиалагч талын/ ажилтнуудыг хөлсөөр авч ажиллуулсан тохиолдолд гэрээг цуцлах.

6.4. Тендерийн материалд тусгагдсан нэр бүхий хүмүүст зааварчилгаа авсны үндсэн дээр засварын ажил гүйцэтгүүлнэ. Шаардлага хангаагүй тохиолдолд гэрээ цуцлах.

ДОЛОО. БАТАЛГААТ ХУГАЦАА

- 7.1. Засварын чанарын баталгаат хугацаа нь тоноглолыг ашиглалтанд хүлээлгэж өгсөн актанд хоёр талын эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулсан өдрөөс хойш 12 сар ба 2200 цаг ажилласан байх.
- 7.2. Баталгаат хугацаанд тоног төхөөрөмжинд гарсан гэмтэл засварын чанар муугаас болсон нь тогтоогдсон тохиолдолд гүйцэтгэгч тал үнэ төлбөргүй засварлана.
- 7.3. Гүйцэтгэгч нь баталгаат хугацаанд гарсан гэмтлийг заасан хугацаанд ирж гүйцэтгээгүй тохиолдолд захиалагчийн талаас туслан гүйцэтгэгч оруулан хийлгэж, хийсэн ажлын хөлсийг үлдэгдэл баталгаат хугацааны 5%-с шилжүүлэн олгоно.
- 7.4. Гэмтлийн актыг хоёр талын хамтарсан комисс тогтоож, хохирлын хэмжээг гаргана.

НАЙМ. ҮНЭ ТӨЛБӨР, ТООЦОО

- 8.1. Гэрээт ажлын үнэ Үнэлгээний хорооны хурлын ЗА-.....тоот тэмдэглэл,ЗА-..... тоот зөвлөмжийн дагуу /**үсгээр** / төгрөг байна. Энэ үнэнд материал, ажлын хөлс, тээвэр, даатгал, гааль, НӨАТ болон бусад зардлууд бүгд багтсан болно.
- 8.2. Санхүүжилтийг гэрээний баталгаажсан гүйцэтгэлээр хуваарийн дагуу гүйцэтгэгчийн дансанд шилжүүлнэ.

| Төлбөрийн хэлбэр | Гэрээгээр тохирсон үнийн дүнгийн % - иар | Гэрээгээр тохирсон үнийн дүнгээс сая төгрөг | Төлбөр хийх хугацаа |
|--|--|---|--|
| Гэрээт засварын гэрээний гүйцэтгэл 50% хүрсэн үед | 40 % | | Төлбөрийн мэдэгдэл гаргасан өдрөөс хойш 30 хоногт багтаан |
| Гэрээт засварын гэрээний гүйцэтгэл 70% хүрсэн үед | 25 % | | Гүйцэтгэл гарган өгч батлагдсан өдрөөс хойш 30 хоногийн дотор |
| Гэрээт засварын ажлыг 100% гүйцэтгэж, гэрээ дүгнэсний дараа | 30% | | Гэрээ дүгнэсэн актанд гарын үсэг зурснаас хойш 30 хоногт багтаан |
| Хүлээлгэн өгснөөс хойш гэмтэл саатал гараагүй тохиолдолд 6 сарын дараа | 5% | | Комиссын шийдвэр гарснаас хойш 30 хоногийн дотор |
| Дүн | 100% | | |

- 8.3. Гэрээт ажлыг хүлээлгэн өгснөөс хойш гүйцэтгэсэн ажилтай холбогдолтой гэмтэл саатал гараагүй тохиолдолд 6 сарын дараа баталгаат хугацааны барьцаа 5%-ийг комиссын шийдвэрийг үндэслэн гүйцэтгэгчид олгож болно.

ЕС. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

- 9.1. Давагдашгүй хүчин зүйлд байгалийн гамшиг, гал түймэр, үер, шуурга, газар хөдлөлт, дайн, эдийн засгийн болон импортын шууд хориг, гэрээ баталсаны дараа үүсэж болзошгүй онцгой нөхцөл байдалд хүргэсэн бусад нөхцлүүд, гэрээг биелүүлэхэд саад учруулсан хүчин зүйлс орно.
- 9.2. Давагдашгүй хүчин зүйлсийн улмаас шууд шалтгаалан гэрээгээр хүлээсэн үүргээ хэсэгчлэн буюу бүхлээр нь биелүүлэхгүйд хүрсэн бол талууд хариуцлага хүлээхгүй.
- 9.3. Давагдашгүй хүчин зүйлс үүссэнээс хойш 7 хоногийн дотор гэрээний үүргээ биелүүлэх бололцоогүй болсон талаар нөгөө талдаа албан ёсоор мэдэгдэнэ.
- 9.4. Хэрэв давагдашгүй хүчин зүйлс гэрээний биелэлтэнд 1 сарын турш үйлчлэх тохиолдолд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж чадахгүй болсон тал цаашид гэрээгээр

хүлээсэн үүргээ биелүүлэхгүй татгалзах эрхтэй. Энэ тохиолдолд талууд гэрээг хүчингүй болгож уг хугацаагаар ажлын гүйцэтгэлийн тооцоог хийж дуусгана.

АРАВ. БУСАД ЗҮЙЛ

10.1. Талууд аль нэгнийхээ зөвшөөрөлгүйгээр энэхүү гэрээг гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.

10.2. Гэрээг монгол хэл дээр 4 хувь үйлдэж талууд захиалагч 3%, гүйцэтгэгч 1%-ийг авах бөгөөд хувиуд нь ижил тэгш хүчинтэй.

10.3. Талууд аль нэг нь гэрээтэй холбогдох мэдээлэл солилцох тохиолдолд мэдээллийг авсан тал хуанлийн 7 хоногт багтаан нөгөө талдаа тавьсан асуудлаар нь тодорхой хариу өгнө

10.4. Энэхүү гэрээнд шууд заагаагүй бусад аливаа асуудлыг Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөж буй хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

10.5. Талуудын санал зөрөөтэй асуудлаар зөвшилцөлд хүрч чадахгүй бол Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

10.6. Шүүхийн шийдвэр нь эцсийн бөгөөд талууд түүнийг заавал биелүүлнэ.

10.7. Гэрээнд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд үндсэн гэрээний салшгүй хэсэг байна.

10.8. Гэрээг хоёр тал зөвшөөрсөн тохиолдолд сунгаж болно.

10.9. Гэрээнд хоёр тал гарын үсэг зурсан өдрөөс эхэлж хүчин төгөлдөр болно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Хаяг: Хан-Уул дүүрэг, 3-хороо,
“ДЦС-3” ТӨХК-ийн
өөрийн байр
Утас:341991, 343575, 341717
Факс: 343024

Хаяг:
.....
.....

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

“ДЦС-3” ТӨХК-ИЙН ТЭРГҮҮН ДЭД
ЗАХИРАЛ, ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР
..... /..... /

..... /..... /

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

..... ХХК-ИЙН
.....ЗАХИРАЛ
..... /..... /

ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР

..... /..... /

Баталгааны маягтыг бэлтгэх санамж

Гэрээний маягт болон тендерийн, гүйцэтгэлийн болон урьдчилгаа төлбөрийн баталгааны зөвшөөрөгдөх маягтуудыг хавсаргав. Тендерт оролцогчид тендерийн хамт тендерийн баталгааг энэ бүлэгт заасан маягтаар ирүүлнэ.

Харин гүйцэтгэлийн болон урьдчилгаа төлбөрийн баталгааг шалгарсан тендерт оролцогч энэ бүлэгт заасан маягтаар ирүүлнэ. Урьдчилгаа төлбөрийн баталгааг ирүүлэх шаардлагагүй бол урьдчилгаа төлбөрийн баталгааны маягтыг тендерийн баримт бичигт хавсаргахгүй.

Тендерт оролцогчийн ирүүлэх тендерийн, гүйцэтгэлийн болон урьдчилгаа төлбөрийн баталгаа нь энэ бүлэгт заасан маягтын дагуу байх ба агуулгын хувьд өөрчлөлт ороогүй боловч өөр хэлбэр /формат/-тэй ирүүлсэн баталгааг захиалагч зөвшөөрнө.

ГҮЙЦЭТГЭЛИЙН БАТАЛГААНЫ МАЯГТ (БАНКНЫ БАТАЛГАА)

[Захиалагч байгууллагын нэр]

[Гүйцэтгэгчийн нэр] нь (цаашид “Гүйцэтгэгч” гэх) нь **[Гэрээний нэр ба ажлын товч тодорхойлолт]** (цаашид “гэрээ” гэх) ажлыг гүйцэтгэх болсонтой ХОЛБОГДУУЛАН,

Гүйцэтгэгч гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгож захиалагчийн хүлээн зөвшөөрөх банкны гаргасан дор дурдсан дүнтэй батлан даалтыг захиалагчид ирүүлэхийг дээрх гэрээнд заасантай ХОЛБОГДУУЛАН,

[Банкны нэр] (цаашид “Банк” гэх) нь дараах батлан даалтыг гаргаж байна:

Банк нь гүйцэтгэгчийн нэрийн өмнөөс **[баталгааны дүн тоогоор, төгрөг]****[дүн үсгээр, төгрөг]**—ээс хэтрэхгүй мөнгөн дүнтэй төлбөрийг **[захиалагчийн нэр]**(цаашид “захиалагч” гэх)-ийн өмнө хариуцаж, гүйцэтгэгч гэрээний үүргээ зөрчсөн тухай захиалагчийн бичгээр гаргасан анхны шаардлагыг хүлээн авсан даруй үл маргалдах журмаар энэхүү төлбөрийг хийх үүрэг хүлээж байна. Ингэхдээ дээр дурдсан **[баталгааны дүн тоогоор, төгрөг]****[дүн үсгээр, төгрөг]**-ийн хүрээнд захиалагчийн шаардсан аливаа дүнг ямарваа нэгэн нотолгоо, үндэслэл болон тайлбар шаардахгүй.

Захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан гэрээний нөхцөл болзол, эсхүл түүний дагуу гүйцэтгэх ажил, эсхүл гэрээний баримт бичигт оруулж болох аливаа өөрчлөлт, нэмэлт нь энэ батлан даалтын дагуу банкны хүлээсэн үүргийг хөндөхгүй ба дээрх өөрчлөлт, нэмэлтийн талаарх аливаа мэдэгдлийг ирүүлэх шаардлагагүй.

Энэ баталгаа нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш /огноо оруулах/ хугацаанд хүчинтэй байна.

Та бүхнийг хүндэтгэсэн,

Банкны эрх бүхий албан тушаалтны гарын үсэг:

Албан тушаал, нэр:

Банкны тамга:

Огноо:

Хаяг:

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2020 оны 02 сарын 10 өдөр

Тендер шалгаруулалтын нэр:

БКЗ-75-39ФБ МАРКИЙН ЗУУХ № 6-ИЙН ИХ ЗАСВАРЫН АЖИЛ

Тендер шалгаруулалтын дугаар:

“ Засвар-02, 2020”

“ДЦС-3” ТӨХК нь эрх бүхий тендерт оролцогчдоос Зуух №6-ийн их засварын ажил гүйцэтгэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүйгээр татан авна уу.

Тендерт оролцох хүсэлтэй байгууллагууд тендерийн баримт бичгээ илгээхийн өмнө **50 000** төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **30** хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

Борлуулалтын орлогын хэмжээ :

600,0 сая төгрөгөөс багагүй байх.

Ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлага:

500,0 сая төгрөгөөс багагүй байх.

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ :

300,0 сая төгрөгөөс багагүй байх.

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо:

Сүүлийн 2 жил

Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх:

Эрчим хүчний яам:

03.3.3. Зуухны угсралт засвар, түүний туршилт тохируулга, дагалдах ажил

350 - 450°C-ээс дээш, 40-80кгх/см² болон түүнээс дээш

Тендерийн хамт дараах үнийн дүн бүхий баталгаа ирүүлнэ.

11 520 000 төгрөг

Тендерийг **2020 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 10 цаг 00 минутаас** өмнө цахим хэлбэрээр ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2020 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн, 10 цаг 30 минутад** нээнэ.

Гадаадын этгээд тендерт оролцох эрхгүй.

Дотоодын давуу эрх тооцно

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо,
ДЦС-3 ТӨХК-ийн захиргаа 2-р давхар, Засвар хяналтын алба.

Утас: 11343575, Факс 976-343575